# ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ЦАГААН ДЭЛ” ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



**Хянасан:**

БОУАӨЯ-ны ХБОБЗГ-ЫН ахлах шинжээч: ___________________________

**Танилцсан:**

“Хөх бишрэлт” ХК-ний гүйцэтгэх захирал Рен Дэвэн

“Хөх бишрэлт” ХК-ний үйлдвэрийн дарга Ц.Ариунцэцэг

**Боловсруулсан:**

Байгаль орчны мэргэжилтэн Ч.Гантөмөр

**Дорноговь аймаг Иххэт сум**

**2025 он**

# Агуулга


НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 6

1.1. Уурхайн товч танилцуулга 6
1.2. Нэр, байршил 6
1.3. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл 7
1.4. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал 7
1.5. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал 7
1.6. Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж 8
1.7. Баяжуулах үйлдвэрийн техонологийн дараалал 9
1.8. Тухайн жилийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө 10

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 11

2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт 11
2.1.1. Олон салаа зам гаргахаас сэргийлэх 12
2.1.2 Машин, техникийн хөдөлгөөнөөс тоос босох 12
2.1.3 Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж гарах хий агаарын чанарт нөлөөлөх 12

2.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт 13
2.2.1 Хаягдлын сангийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах, тогтмол үзлэг хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ 14
2.2.2 Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах 14

2.3 Хөрсөн үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт 15
2.3.1 Хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийх 16
2.3.2 Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх 16
2.3.3. Асгаралтай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх 16
2.3.4 Химийн бодисын агуулахаас асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол ажлын байрны үзлэг хийх, аливаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх 17
2.3.5. Шимт хөрсний овоолгын ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах 17

2.4 Газрын хэвлий, ургамалан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт 18
2.4.1 Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх 19
2.4.2 Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх 19
2.4.3. Уурхайн талбайд нэн ховор, ховор зүйлийн ургамал таарсан тохиолдолд шилжүүлэн суулгах арга хэмжээ авах 19
2.4.4 Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх 20

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 21

3.1 Биологийн нөхөн сэргээлт 21
3.1.1 Шинээр хөндөгдөж буй газраас шимт хөрсийг хуулж, овоолгод хадгалах. Хөндөгдөх газар бүрт байгаль орчны мэргэжилтэн үзлэг хийж хуулах шимт хөрсний зузааныг тодорхойлох. 21

**3.2 Техникийн нөхөн сэргээлт** 21
3.1.2 Холбогдох стандартын шаардлагын хүрээнд шимт хөрсний овоолгын үржил шим, хэмжээг алдагдуулахгүйн тулд ургамалжуулалтын арга хэмжээг эхлүүлэх 21
**ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** 22
**4.1 Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох** 23
**4.2. Орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдож, хашиж, хамгаалах боломжтой 1 булаг сонгож, хашиж хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх** 24
**ТАВДУГААР БҮЛЭГ: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** 25
**ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** 26
**6.1. Биет бус өв** 27
6.1.1Иххэт сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өвс рүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх 27
**6.2. Журам** 27
6.2.1 Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг шинэчлэх 27
6.1.3. Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах 28
**ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ** 29
**7.1. Үйлдвэрийн болзошгүй осол** 32
7.1.1. Баяжуулах үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулах 32
7.1.2. Үйлдвэрийн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах 32
7.1.3. Үйлдвэрийн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох 32
7.1.4. Аюулгүй ажиллагааны хэлтэс ажлын байр, талбаруудад үзлэг хийж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх 32
**7.2. Химийн бодис тээвэрлэлт** 33
7.2.1. Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэр лүү тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, зааварчилгаа өгөх 33
**7.3. Химийн бодисын хадгалалт** 33
7.3.1. Химийн бодисыг хүлээн авахдаа сав, баглаа боодол, тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авах 33
7.3.2. Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах 34
7.3.3. Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээг гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах 34
7.3.4. Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх 34
7.3.5. Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх 34

7.3.6. Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх _____ 34

7.3.7.Төслийн талбай орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох _____ 34

**НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ _____ 35**

**8.1. Ахуйн хог хаягдал _____ 37**

8.1.1. Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах, бүртгэл хөтлөх _____ 37

8.1.2. Хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих үзлэг шалгалт хийх _____ 37

8.1.3. Компанийн багц дотоод сургалтын хүрээнд нийт ажилчдад хог хаягдалтай холбоотой сургалт зохион байгуулах _____ 38

8.1.4. Төслийн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих _____ 38

**8.2. Аюултай хог хаягдал _____ 39**

8.2.1. Аюултай хог хаягдал тээвэрлэх болон устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгч акт үйлдэх _____ 39

8.2.2. Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авч, бүртгүүлэх _____ 39

8.2.3.Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх, устгалд оруулах _____ 40

8.2.4. Техник тоног төхөөрөмжийн ашигласан хаягдал тосыг үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тосолгоонд дахин ашиглах, тухай бүр ашиглалтын бүртгэл хөтлөх _____ 40

8.2.5. Үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэх, ангилан төрөлжүүлж бүртгэх, түр цэгт хадгалах, устгах үйлдвэрт нийлүүлэх _____ 40

8.2.6. Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлнэ _____ 40

**ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ _____ 41**

**9.1 Зөвлөх үйлчилгээний ААН-тэй гэрээлэх _____ 42**

9.1.1 Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах _____ 42

9.1.2 Үйлдвэрийн БОННҮ нэмэлт тодотгол мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хийлгэх _____ 43

**9.2. Ногоон байгууламж _____ 44**

9.2.1 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн хашаан дотор модны суулгац тарих _____ 44

9.2.2 Баяжуулах үйлдвэр дээр тарьсан мод, бутлаг ургамлын ургалт, өсөлт, ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжлийн ойжуулалтын инженерээс зөвлөгөө авч, хамтран ажиллах _____ 44

**9.3 Орон нутаг, хамтын ажиллагаа _____ 45**

9.3.1. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдэд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах _____ 45

**АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР _____ 46**

**10.1 Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд ус, хөрс, агаар, ургамал, амьтны дээжлэлт, хэмжилт, шинжилгээ хийх хяналтын цэгүүдийн байршлыг тодорхойлох, тухайн цэгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, кодлох болон дугаарлалтын систем бий болгох 47**
**10.2 Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар гүйцэтгэх, үр дүнг боловсруулах 47**
**10.3 Хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх 48**
**10.4 Ундны усны дээж авч химийн болон бактерийн үзүүлэлтийг шинжлүүлэх 48**
**АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ 49**
**11.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах 49**
**11.2 Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулах 49**
**ДҮГНЭЛТ 50**
**Хавсралт материал 53**
1. Улсын бүртгэлийн гэрчилгээ 53
2. Ус ашиглах дүгнэлт 55
3. Ус ашиглах зөвшөөрөл 60
4. Хаягдал усны дүгнэлт 61
5. Бохир усны төлбөрийн гэрээ дүгнэсэн акт 62
6. Хөрсний шинжилгээний хариу 64
7. Засаг даргын тамгын газартай “Хог хаягдал ачиж тээвэрлэх тухай” гэрээ 66
8. Аюултай хог дагалдах бичиг 68
9. Байгаль орчны хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээний төсөл 73
10. Усны төлбөр төлсөн баримт 76
11. Сургалтын төлбөр төлсөн баримт 77
12. ЗДТГ гэрээ болон говийн бүсийн шагай харвааны санхүүжилт 78
13. Волейболын холбооны хандив болон мод худалдан авсан баримт 79
14. Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ 80
15. Химийн хортой аюултай бодисын хаягдал устгах ажил гүйцэтгэх гэрээ 81

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ:**

ЗУРАГ 1ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАЙРШИЛ 7
ЗУРАГ 2 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН СХЕМ 8
ЗУРАГ 3 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХОЛБОЛТЫН СХЕМ 9
ЗУРАГ 4 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН СХЕМ 10
ЗУРАГ 5 ХУРДНЫ ХЯЗГААР ТОГТООСОН БОЛОН ЗОРЧИХ ХЭСГИЙГ ТОГТООСОН ТЭМДГҮҮД 12
ЗУРАГ 6 ЗАМ УСАЛГААНЫ МАШИН 12
ЗУРАГ 7 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН УС АШИГЛАЛТЫН ТӨЛБӨР 14
ЗУРАГ 8 БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРТ АШИГЛАГДАЖ БУЙ ДУГУЙТ АЧИГЧ 16
ЗУРАГ 9 АСГАРАЛТИЙН ИЖ БҮРДЭЛ БАЙРЛУУЛСАН БАЙДАЛ 16
ЗУРАГ 10 ШИМТ ХӨРСНИЙ ОВООЛГОД ХЭЛБЭРЖҮҮЛЭЛТ ХИЙЖ, ТАРИЛТАД БЭЛДЭЖ БУЙ БАЙДАЛ 17
ЗУРАГ 11 НААДМЫН ТАЛБАЙГ УСАЛЖ БУЙ БАЙДАЛ 19
ЗУРАГ 12 ХАБЭА-Н АЖИЛТАН ГАЛЫН АЮУЛААС СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ ОРЖ БУЙ БАЙДАЛ 19
ЗУРАГ 13 ҮЙЛДВЭРИЙН ХАШАА ШОРООН ДАЛАНГААР ЗОГООНО ТАТСАН БАЙДАЛ 20
ЗУРАГ 14 СУМЫН ТӨВИЙН ХОГИЙН ЦЭГИЙН ИЛ ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ 23
ЗУРАГ 15 ЧУЛУУ ОЛБОРЛОСОН ГАЗРЫН ХАШАА БАРЬЖ БАЙГАА ҮЕ 23
ЗУРАГ 16 НОГООН ТЭЖЭЭЛ ХУРААЖ УРГАСАН БАЙДАЛ 24

ЗУРАГ 17 ХАШААТЫН БУЛГИЙН ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛСАН БАЙДАЛ 24
ЗУРАГ 18 САНХҮҮЖИЛТ ШИЛЖҮҮЛСЭН БАРИМТ 27
ЗУРАГ 19 БАТЛАГДСАН ТҮҮХ СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ 27
ЗУРАГ 20 “ТҮҮХ СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ”-Н СУРГАЛТ ХИЙЖ БУЙ БАЙДАЛ 28
ЗУРАГ 21 ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ 32
ЗУРАГ 22 АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ЗААВАРЧИЛГААНЫ ТЭМДЭГЛЭЛ 33
ЗУРАГ 23 ХӨДӨЛМӨР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА 33
ЗУРАГ 24 ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ 37
ЗУРАГ 25 АНГИЛАН ЯЛГАХ ХОГИЙН САВ 37
ЗУРАГ 26 СУРГАЛТ ОРЖ БУЙ БАЙДАЛ 38
ЗУРАГ 27 АНГИЛАН ЯЛГАХ ХОГИЙН САВНЫ ТЭМДЭГ ТЭМДЭГЛЭГЭЭ 38
ЗУРАГ 28 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН АКТ 39
ЗУРАГ 29 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ ҮЕИЙН ЗУРАГ 39
ЗУРАГ 30 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ 40
ЗУРАГ 31 ХАБЭА-Н СУРГАЛТ 42
ЗУРАГ 32 ХАБЭА-Н СУРГАЛТ АВСАН БҮРТГЭЛ 42
ЗУРАГ 33 ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ 43
ЗУРАГ 34 ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРЬЖ БУЙ БАЙДАЛ 44
ЗУРАГ 35 АМЬТАН НУТАГШУУЛАХ ТАЙЛАН, ХҮЛЭЭЛЦЭХ БАРИМТ 45
ЗУРАГ 36 ИХХЭТ СУМЫН БАЯН-УУЛ ХАЙРХАНЫ ОРЧИМД ТАРВАГА СЭРГЭЭН НУТАГШУУЛЖ БАЙНА 45
ЗУРАГ 37 АГААРЫН ХЭМЖИЛТ БОЛОН ҮР ДҮН 47
ЗУРАГ 38 ХӨРСНИЙ ДЭЭЖЛЭЛТИЙН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРИУ 48

## ХҮСНЭГТ ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛ ........ 11
ХҮСНЭГТ 2 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ........ 13
ХҮСНЭГТ 3 ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ........ 15
ХҮСНЭГТ 4 ГАЗРЫН ХЭВЛИЙ, УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ ........ 18
ХҮСНЭГТ 5 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 22
ХҮСНЭГТ 6 ТҮҮХ СОЁЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 26
ХҮСНЭГТ 7 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 30
ХҮСНЭГТ 8 ХОГ ХАЯГДЛЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 35
ХҮСНЭГТ 9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 41
ХҮСНЭГТ 10 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ........ 46
ХҮСНЭГТ 11 НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД БОМТ-НИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ........ 49

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ:

АМГ - Ашигт малтмалын газар

ЭБМЗ – Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл

БОУАӨЯ- Байгаль орчин, уур амьсгал, өөрчлөлтийн яам

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Уурхайн товч танилцуулга

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Жонш баяжуулах үйлдвэр” нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт Монголросцветмет ХХК-ний ашиглаж байсан Хамар-Усны хайлуур жоншны ордын ил уурхайгаас олборлож гаргасан балансын бус жоншны хүдрийн овоолгыг түшиглэн жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан бөгөөд 2021 онд “Сити-Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайшаншин юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэж жилд бүрэн хүчин чадлаараа 300.0 мян.тн хүдэр боловсруулан баяжуулж, ФФ97 маркийн 76.3 мян.тн жоншны баяжмалыг гаргах хүчин чадалтайгаар ажиллахаар ТЭЗҮ /тодотгол/-ыг “Ертөнцийн зүг” ХХК боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Ашигт малтмал газрын тосны газрын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 11-р сарын 23-ны өдрийн Т/20-11-03 тоот дүгнэлтээр баталгаажуулжээ.

“Хөх бишрэлт” ХХК нь “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг 2017 онд “Ашид Ананда” ХХК-аар хийлгүүлж, 2022 онд “ЕАСС” ХХК-аар нэмэлт тодотголыг тус тус хийлгэж, БОУАӨЯ-р батлуулсан. Мөн төлөвлөгөөт жилд БОННҮ-г шинэчлэн боловсруулж, нэмэлт тодотгол хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618-р тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч “Хөх Бишрэлт” ХХК нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, тус журмын дагуу байгуулагдсан ажлын хэсэгт дээрх төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлүүлж 92.7%-ийн үнэлгээ авсан болно.

## 1.2. Нэр, байршил

“Хөх бишрэлт” ХХК-ийн “Цагаан Дэлийн жонш баяжуулах үйлдвэр” төсөл нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт, Улаанбаатар хотоос зүүн тийш 345 км, төмөр замын Бор-Өндөр өртөөнөөс зүүн тийш 50 км, Иххэт сумаас баруун тийш 5 км-т оршиж байна.




*Зураг 1Төслийн талбайн байршил*

## 1.3. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл

| | |
|---|---|
| **Аж ахуйн нэгжийн нэр:** | “Хөх Бишрэлт” ХХК |
| **Аж ахуйн нэгж бүртгэлийн дугаар:** | 9019078088 |
| **Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:** | Гадаад худалдаа |
| **Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:** | Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 4 дүгээр хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж, 35-3 тоот |
| **Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:** | Гүйцэтгэх захирал REN DEWEN, 96620509, huhbishrelt.5878@yahoo.com |
| **Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:** | Үйлдвэрийн дарга Ц.Ариунцэцэг, 99153477, huhbishrelt.5878@yahoo.com |

## 1.4. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Жонш баяжуулах үйлдвэрийн дэд бүтэц, зохион байгуулалтийн хувьд түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах, хадгалах хэсэг, хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг, эргэлтийн усны сав, цэвэр усны худаг, ус дамжуулах насос, урвалж бодисын агуулах, цахилгаан хангамжийн хэсэг, хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг, ажилчдын байр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

## 1.5. Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал

Цагаан Дэл жонш баяжуулах үйлдвэр нь жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан. 2021 онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотгол хийгдэж “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайншаншин Юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 300.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. 2025

онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотголыг “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Степ флюорит” ХХК-ийн Ноён нэртэй хайлуур жоншны орд, “Новодин” ХХК-ийн Баян-улаан нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 150.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ95-ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 2017 онд бүрэн хэрэгжиж, 2018 оноос эхлэн бүтээгдэхүүн гаргах, үйл ажиллагаа эхэлсэн байдаг.

## 1.6. Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмж

Жоншны хүдэр боловсруулалтын технологийн процесс дараах схемийн дагуу явагдана. Үүнд:

- Хүдрийг 5.0 мян.м2 талбайд овоолж дундажлах:
- Том бутлалтын хэсэг
- Дунд бутлалтын хэсэг (хяналтын шигшилттэй)
- Нунтаглалт (ангилалтын битүү циклээр ажиллах)
- Үндсэн флотаци, хяналтын флотаци, 6 үе шаттай цэвэрлэгээний флотаци,
- Баяжмалын өтгөрүүлэлт,шүүх , хатаах
- Хаягдлын аж ахуй зэрэг процессоос бүрдэнэ.




*Зураг 2 Баяжуулах үйлдвэрийн схем*



*Зураг 3 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн холболтын схем*

## 1.7. Баяжуулах үйлдвэрийн техонологийн дараалал

Баяжуулах үйлдвэрийн хүдэр бутлах хэсэг нь 2 шатны бутлуур, 1 шатны шигшүүрээс бүрдэнэ. Анхдагч хүдрийг хяналтын шигшилттэй 2 шатны бутлалтын схемээр буталж хүдрийн ширхэглэлийг 12мм болгоно.

Анхдагч хүдрийн овоолгоос утгуурт ачигчийн тусламжтай хүдрийг хүлээн авах бункерт тэжээх бөгөөд бункерын доор суурилагдсан хавтант тэжээгүүр нь нэгдүгээр шатны хацарт бутлуурыг тэжээнэ. Нэгдүгээр шатны хацарт бутлуурын хүлээн авах хүдрийн хамгийн том ширхэглэл -400 мм байх бөгөөд бутлуураас -80 мм-ийн ширхэглэлтэй хүдэр гарна.

Хяналтын шигшилтийн зорилго нь бутлагдсан хүдрийн ширхэглэлд хяналт тавих болон хоёрдугаар шатны бутлуурт орох шаардлагагүй хүдрийг ялгана. Бутлах цехэд ажиллах шигшүүрийн торны нүхний хэмжээ 15 мм байна. Хяналтын шигшүүрийн торны дээд ангийг (+12 мм-ийн анги) хоёрдугаар шатны бутлуур (1-р шугам хацарт бутлуур, 2-р шугам конусан бутлуур)-т өгөх бөгөөд бутлуураас гарах хүдрийн ширхэглэл -12мм байна.

***<u>Хүдэр жигдэрүүлэлт:</u>***

Баяжуулах процесст орж байгаа хүдрийн шинж чанар, хүдэр дэх ашигт болон хорт хольцын агуулгын өөрчлөлт нь үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим, баяжмалын чанар, бүтээгдэхүүний гарц, минерал авалт зэрэг нөлөөлдөг. Ийм учраас баяжуулах үйлдвэрийн технологийн процессыг хэвийн жигд явуулах зорилгоор хүдэр жигдрүүлэлтийн ажил хийгддэг. Жонш олборлогчдоос нийлүүлж буй түүхий эдийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр жигдрүүлэх талбайд зөөвөрлөн авчирч, жоншны агуулга болон хүдэр дэх карбонатын агуулгаас хамааруулан үечлэн овоолго байгуулах замаар хүдрийг жигдрүүлэн баяжуулахад бэлтгэн хадгална. Хүдрийг холих үедээ хүдрийн бүтцийн чанарыг судлах шаардлагатай.

***<u>Баяжуулалт:</u>***

Баяжуулах үйлдвэр нь түүхий эд буулган жигдрүүлэх талбай, хүдэр бутлан ангилах хэсэг, нунтаглан баяжуулах хэсэг, баяжмал шүүн хатаах хэсэг, баяжмал савлах,хадгалах хэсэг,хаягдлын аж ахуй, засвар үйлчилгээний хэсэг,эргэлтийн усны сав, цэвэр усны худаг, ус дамжуулах насос,урвалж бодисын агуулах,цахилгаан хангамжийн хэсэг,хяналтын лаборатори, уурын зуухны хэсэг,ажилчдын байр контор зэргээс бүрдэнэ.




*Зураг 4 Баяжуулах үйлдвэрийн схем*

## 1.8. Тухайн жилийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Цагаан Дэл жонш баяжуулах үйлдвэр нь жилд 150.0 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар 2017 онд баригдсан. 2021 онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотгол хийгдэж “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Тайншаншин Юань” ХХК-ийн Дай-Уул нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 300.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай болсон. Бид үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагааг батлагдсан ТЭЗҮ-н дагуу явуулж байна.

2025 онд төслийн ТЭЗҮ-нд нэмэлт тодотголыг “Сити Сүлжээ” ХХК-ийн Дэлгэр-3 нэртэй хайлуур жоншны орд, “Степ флюорит” ХХК-ийн Ноён нэртэй хайлуур жоншны орд, “Новодин” ХХК-ийн Баян-улаан нэртэй хайлуур жоншны ордуудыг түшиглэн жилд 150.0 мян.тонн хүчин чадалтайгаар ФФ95-ФФ97 маркийн жоншны баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Үйлдвэрийн 2025 оны ашиглалтын төлөвлөгөөнд 70.0 мян.тн жоншны хүдэр боловсруулан баяжуулж 16.2 мян.тн ФФ97 маркийн баяжмал гаргахаар тусгасан болно.

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний агаарын чанарт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах 6 арга хэмжээг төлөвлөж, 3 арга хэмжээг хэрэгжүүлэв.

*Хүснэгт 1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэл*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Давтамж | Хэрэгжилт | Биелэлт, % |
|---|---|---|---|---|---|
| 1. | Олон салаа зам гаргахаас сэргийлэх | Уурхайн технологийн зам | Төлөвлөгөөт жилд | Олон салаа зам гаргахаас сэргийлэх шаардлагагүй замыг хаах, тэмдэг байрлуулах, хурдны хязгаар тогтоох | 100 % |
| 2. | Машин, техникийн хөдөлгөөнөөс тоос босох | Уурхайн технологийн зам | Үйл ажиллагааны улирал тутам | Баяжуулах үйлдвэрийн тоос босох боломжтой байршлуудад тоосны болон агаарын бохирдлын хэмжилтийг тогтмол хийх. Стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэв. | 100 % |
| 3. | Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж гарах хий агаарын чанарт нөлөөлөх | Хүдэр бутлах төхөөрөмж орчим | 5000 км тутамд | Суурин тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийсэн. | 100 % |

## 2.1.1. Олон салаа зам гаргахаас сэргийлэх

Үйлдвэрийн талбайд тогтсон замуудаар тээврийн хөдөлгөөн үйлддэг бөгөөд автозамуудад хурдны хязгаарын 5, 10 км/цаг явах тэмдэг, тэмдэглэгээнүүдийг байршуулсан. Төслийн талбайд замын тэмдэг тэмдэглэгээ нийт 4 ш байрлуулсан.



*Зураг 5 Хурдны хязгаар тогтоосон болон зорчих хэсгийг тогтоосон тэмдгүүд*

## 2.1.2 Машин, техникийн хөдөлгөөнөөс тоос босох

Тайлант жилд хур тунадас их унасан учир зам талбайн усалгаа тогтмол хийгээгүй. Гэхдээ хур тунадас ороогүй, хуурайшилттай буюу зам талбайгаас тоос босох тохиолдолд усалгааг тухай бүрд хэрэгжүүлэн ажилласан.



*Зураг 6 Зам усалгааны машин*

## 2.1.3 Суурин болон хөдөлгөөнт тоног төхөөрөмж гарах хий агаарын чанарт нөлөөлөх

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайн засвар үйлчилгээний хүрээнд баяжуулах үйлдвэрийн нам даралтын зууханд их засвар, үйлчилгээг мөн хэрэгжүүлэн ажилласан.

## 2.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний усны чанарт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах 2 арга хэмжээг төлөвлөж, 100 хувь хэрэгжүүлэв.

*Хүснэгт 2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Давтамж | Хэрэгжилт | Биелэлт, % |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хаягдлын сангийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах, тогтмол үзлэг хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх | Уурхайн хэмжээнд | Тогтмол | Холбогдох ажилчид хаягдлын сангийн үзлэгийг хуваарийн дагуу хийж ажилласан. | 100 % |
| 2. | Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах | Уурхайн хэмжээнд | Жилд 1 удаа | Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон татварын улсын байцаагч нарыг байлцуулан худгуудын тоолуурын заалтын акт үйлдэж, түүн дээр үндэслэн нэхэмжлэх гаргуулан авч, төлбөрийг төлөн ажилласан. | 100 % |

**2.2.1 Хаягдлын сангийн тогтвортой байдал, аюулгүй ажиллагааг хангах, тогтмол үзлэг хийх, зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ**

Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны ажилтан болон баяжуулах үйлдвэрийн холбогдох ажилчид хаягдлын сан, далан, түүний хамаарал бүхий тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг өдөр тутам хийж ажилласан. Тухайн үзлэгийн үеэр ямарваа нэг анхаарал татахуйц дутагдал, зөрчил, эвдрэл илрээгүй болно.

**2.2.2 Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах**

Баяжуулах үйлдвэр болон унд ахуйн хэрэглээнд ашигласан усны хэрэглээ, худгуудын тоолуурын заалтыг Иххэт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон Татварын улсын байцаагч нарыг байлцуулан актаар баталгаажуулан, төлбөрийн нэхэмжлэхийг гаргуулан ажилласан. Тус төлбөрийн нэхэмжлэх дээр үндэслэн ус ашигласны төлбөрийг холбогдох төрийн дансанд байрлуулан ажилласан байна.



ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР №429

2025 оны 10 сарын 16-ны өдөр

| | Дт данс | ДҮН |
|---|---|---|
| Төлөгч: Хөх Бишрэлт ХХК<br>Банк: ХААН БАНК | 5166055499 | 39,000,000.00 |
| Хүлээн авагч: ТАТВАРЫН АЛБА<br>Банк: ХААН БАНК | 3250705044475 | |
| Мөнгөний дүн /үсгээр/: Гучин есөн сая төгрөг мөнгө<br>Барааг хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн<br>Төлбөрийн зориулалт: Барааны болон ажил үйлчилгээний нэр, дагалдах баримтын №<br>РД: 5878756 Хөх бишрэлт ХХК-Усны төлбөр | | |

Банкинд гүйлгээ хийсэн

2025 он 10 сар 16 өдөр

Дарга.............................. РЕН.ДЕВЕН

Тамга

тэмдэг гарын үсэг

*Зураг 7 Баяжуулах үйлдвэрийн ус ашиглалтын төлбөр*

## 2.3 Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хөрсөн бүрхэвчид нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах 5 арга хэмжээг төлөвлөж, 100 хувь хэрэгжүүлэв.

*Хүснэгт 3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт*

| № | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Давтамж | Хэрэгжилт | Биелэлт, % |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийх | | Улирал тутам | Үйл ажиллагаанд ашиглагддаг хөнгөн тэрэгнүүдийн засвар үйлчилгээг 5000 км тутамд хийж ажиллаж байна. | 100 % |
| 2. | Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх | | | Баяжуулах үйлдвэр дотор байрлах бетон талбайд тоног төхөөрөмж, хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. | 100 % |
| 3. | Асгаралтай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх | | 10 | Аюулгүй ажиллагааны ажилтан сар бүр асгаралттай тэмцэх иж бүрдлийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, шаардлагатай тохиолдолд цэнэглэлт хийж ажиллаж байна. | 100 % |
| 4. | Химийн бодисын агуулахаас асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол ажлын байрны үзлэг хийх, аливаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх | | | Аюулгүй ажиллагааны ажилтан, баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын агуулахад тогтмол үзлэгийг хийж, аливаа аюул, эрсдэл, асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. | 100 % |
| 5. | Шимт хөрсний овоолгийн ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах | | | Шимт хөрсний овоолгод ургамал тарих ажлын хүрээнд ургамлын үр тарьсан. | 100 % |

### 2.3.1 Хөнгөн тэрэгний засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийх

Үйл ажиллагаанд ашиглагддаг хөнгөн тэрэгнүүдийн засвар үйлчилгээг 5000 км тутамд хийж ажиллаж байна. Засвар үйлчилгээний хүрээнд тос, тосолгооны шингэн солих, шүүрийг цэвэрлэх болон солих, бусад үзлэг болон үйлчилгээг хийж ажилласан.




*Зураг 8 Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй дугуйт ачигч*

### 2.3.2 Тоног төхөөрөмж, хөнгөн тэрэг, технологийн хүнд машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын хөрсөнд нэвчилт үүсгэхгүй талбайд хийх

Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг, засвар үйлчилгээг хуваарийн дагуу тогтмол хэрэгжүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагаанд ашиглагддаг хөнгөн тэрэгнүүдийн засвар үйлчилгээг 5000 км тутамд хийж ажиллаж байна. Засвар үйлчилгээний хүрээнд тос, тосолгооны шингэн солих, шүүрийг цэвэрлэх болон солих, бусад үзлэг болон үйлчилгээг хийж ажилласан.

### 2.3.3. Асгаралтай тэмцэх иж бүрдлийн бүрэн байдлын үзлэгийн сар тутам гүйцэтгэх, шаардлагатай тохиолдолд тухайн бүрд цэнэглэх

Баяжуулах үйлдвэр болон химийн бодисын агуулахад шингээгч материал, аюулын үед ашиглах тоног төхөөрөмж болон модны үртэс бүхий асгаралттай тэмцэх иж бүрдлүүд байрлуулсан. Тухайн асгаралттай тэмцэх иж бүрдлүүдийн үзлэгийг аюулгүй ажиллагааны ажилтан тогтмол хэрэгжүүлсэн бөгөөд шаардлагатай тохиолдолд цэнэглэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.



*Зураг 9 Асгаралтийн иж бүрдэл байрлуулсан байдал*

### 2.3.4 Химийн бодисын агуулахаас асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол ажлын байрны үзлэг хийх, аливаа дутагдал, зөрчил илэрсэн тохиолдолд тухай бүр сайжруулах, залруулах арга хэмжээ хэрэгжүүлэх

Аюулгүй ажиллагааны ажилтан, баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын агуулахад тогтмол үзлэгийг хийж, аливаа аюул, эрсдэл, асгаралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Тайлант жилд химийн бодисын агуулахын үзлэгээр ямарваа анхаарал татахуйц дутагдал, зөрчил илрээгүй болно.

### 2.3.5. Шимт хөрсний овоолгын ахилт хийгдэхгүй хэсгийг хэлбэржүүлж, шимт чанарыг алдагдахаас сэргийлж ургамалжуулах

Шимт хөрсний чанар, хэмжээ, хэлбэрийг алдагдахаас сэргийлэн шимт хөрсний овоолгод хэлбэржүүлэлт хийж, зүлэгний үр тарьсан.



*Зураг 10 Шимт хөрсний овоолгод хэлбэржүүлэлт хийж, тарилтад бэлдэж буй байдал*

## 2.4 Газрын хэвлий, ургамалан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний газрын хэвлий, ургамалан нөмрөг, амьтны аймагт нөлөөлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараах 4 арга хэмжээг төлөвлөж, 100 хувь хэрэгжүүлэв.

*Хүснэгт 4 Газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Хамрах хүрээ | Давтамж | Хэрэгжилт | Биелэлт, % |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ургамлын ургах нөхцөл багасах | Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх | Хөндөгдөх газар | Тухай бүрд | Тайлант жилд хур тунадас сайн орсон. Зам талбайн усалгааг хийсэн болно. | 100 % |
| 2 | Тал хээрийн түймэр ургамалан нөмрөгт нөлөөлөх | Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх | Гал түймэр тохиож болох газар орчимд | Сар бүр | Галын аюулаас аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хэрэгжүүлсэн бөгөөд ХАБЭА-н ажилтан нь нийт 76 ажилтанд галын аюулаас сэргийлэх онол болон практик сургалтыг орсон. | 100 % |
| **3** | Ховордсон ургамал устах | Уурхайн талбайд нэн ховор, ховор зүйлийн ургамал таарсан тохиолдолд шилжүүлэн суулгах арга хэмжээ авах | Хөндөгдөх газар | Тухай бүрд | Нэн ховор байдлын ургамал байхгүй болно. | 100 % |
| 4. | Үйл ажиллагаанаас зэрлэг амьтанд нөлөөлөх | Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх | Төслийн хашаа | Сар бүр | Баяжуулах үйлдвэрийн шаардлагатай газруудад мал амьтан орохоос сэргийлсэн хашаа суурилуулах ажлыг хийж байгаа бөгөөд хараахан дуусаагүй байна. Мөн хашаа дагасан мод тарихаар төлөвлөж байна. | 100 % |

### 2.4.1 Тоос босож буй зам талбайд усалгааг тогтмол хийх

2025 онд хур бороо их унасан тул тоос босох асуудал харьцангуй бага. Үйлдвэрийн бутлуурын талбай болон Иххэт сумын наадмын талбайн усалгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.



*Зураг 11 Наадмын талбайг усалж буй байдал*

### 2.4.2 Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх

Галын аюулаас аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгийг хэрэгжүүлсэн бөгөөд ХАБЭА ажилтан нь нийт 76 ажилтанд галын аюулаас сэргийлэх онол болон практик сургалтыг орсон.




*Зураг 12 ХАБЭА-н ажилтан галын аюулаас сэргийлэх сургалт орж буй байдал*

### 2.4.3. Уурхайн талбайд нэн ховор, ховор зүйлийн ургамал таарсан тохиолдолд шилжүүлэн суулгах арга хэмжээ авах

Үйлдвэрийн ашиглалтын талбай нь шимт хөрсийг хуулж барилга байгууламж хүдэр буулгах талбай зэргийг төвлөж ашиглаж байгаа тул ургамал ургах орчин нөхцөл байхгүй.

### 2.4.4 Төслийн хашааны бүрэн бүтэн байдлыг хянаж мал, амьтан орохоос сэргийлж үзлэг шалгалт хийх

Үйлдвэрийн машин орж гарах харуулын пост хажууд хашаа барьж бусад хэсгийг далан босгож зогооно татаж мал амьтан орж ирэхээс сэргийлэн ажиллаж байна.





*Зураг 13 Үйлдвэрийн хашаа шороон далангаар зогооно татсан байдал*

## ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөөт жилд жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүдэн шинээр газар хөндөөгүй тул нөхөн сэргээлт хийх шаардлага бүхий газар байхгүй тул шимт хөрсний овоолго, түүний үржил шим, хэмжээг алдагдуулахгүй байх, өнгөрсөн жилүүдэд хийгдсэн нөхөн сэргээлттэй хамаарал бүхий арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүлж байна.

*Биологийн нөхөн болон техникийн нөхөн сэргээлтийн биелэлт*

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Тоо хэмжээ | Хэрэгжилтийн товч тодорхойлолт | Биелэлт, 100 % |
|---|---|---|---|---|---|
| 1 | Биологийн нөхөн сэргээлт | Шимт хөрс | га | Шинээр хөндөгдөж буй газраас шимт хөрсийг хуулж, овоолгод хадгалах. Хөндөгдөх газар бүрт байгаль орчны мэргэжилтэн үзлэг хийж хуулах шимт хөрсний зузааныг тодорхойлно. | 100 % |
| 2 | Техникийн нөхөн сэргээлт | Шимт хөрс | га | Холбогдох стандартын шаардлагын хүрээнд шимт хөрсний овоолгын үржил шим, хэмжээг алдагдуулахгүйн тулд ургамалжуулалтын арга хэмжээг эхлүүлэх | 100 % |

### 3.1 Биологийн нөхөн сэргээлт

#### 3.1.1 Шинээр хөндөгдөж буй газраас шимт хөрсийг хуулж, овоолгод хадгалах. Хөндөгдөх газар бүрт байгаль орчны мэргэжилтэн үзлэг хийж хуулах шимт хөрсний зузааныг тодорхойлох.

2025 онд үйлдвэрийн талбайд шинээр шимт хөрс хуулагдаагүй. Хэрвээ шимт хөрс хуулах ажил хийгдвэл говийн нөхцөлийн онцлогоос хамаарч 0.30 – 0.35 см зузаантай шимт хөрсийг хуулна.

### 3.2 Техникийн нөхөн сэргээлт

#### 3.1.2 Холбогдох стандартын шаардлагын хүрээнд шимт хөрсний овоолгын үржил шим, хэмжээг алдагдуулахгүйн тулд ургамалжуулалтын арга хэмжээг эхлүүлэх

Энэ жил шимт хөрсөн дээр нэмж ургамалжуулалт хийгдээгүй ба өмнөх өнд тариалалт хийсэн ургамал мод бутнуудыг усалж арчилсан.

## ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөх Бишрэлт ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд бид 2025 онд дүйцүүлэн нөхөн сэргээлтийн арга хэмжээнүүдийг төлөвлөж хэрэгжүүллээ.

*Хүснэгт 5 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт, 100 % |
|---|---|---|---|---|---|
| **1.** | Төслийн “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө боловсруулах | Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох | Дүйцүүлэн хамгаалах хэрэгжих газар нутаг | Сумын төвийн хогийн цэгийг хавар намар ковшоор түрж, экскаватор ил задгай хогийг булшилсан. Сумын төвийн мод үржүүлгийн талбайд торон хашааны тусламж үзүүлсэн. | 100% |
| 2. | Газрын доорх усны хамгаалалт | Орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдож, хашиж, хамгаалах боломжтой 1 булаг сонгож, хашиж хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх | Эвдэрсэн газар | Усны тухай хулийн дагуу Хашаатын булгийн эхийг хашиж хамгаалж хүлээлгэж өгөв. | 100% |

**4.1 Холбогдох орон нутгийн засаг даргын тамгын газар, БОАЖГ-тай хамтран хэрэгжүүлж болох биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хувилбаруудыг тодорхойлох**

Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын тамгын газартай ярилцсаны үндсэн дээр сумын төвийн хогийн цэгийн задгай хогийг булшлах, сумын төвийн хойд талд орших мод үржүүлгийн талбайд торон хашааны тусламж үзүүлсэн.



*Зураг 14 Сумын төвийн хогийн цэгийн ил хог хаягдлыг булшлах*

Иххэт сумын 1 дүгээр багийн нутагт хууль бусаар чулуу олборлосон газарт идэвхтэн байгаль хамгаалагчтай хамтарч 5га газрын хашаажуулан ногоон ургамлын үр худалдан авч тариалалт хийж намар нутгийн иргэд  ногоон тэжээл хурааж авсан.



*Зураг 15 Чулуу олборлосон газрын хашаа барьж байгаа үе*

Намар тариа хураалтын үеэр ногоон тэжээлийн ургамал нь сайн ургаж орон нутгийн иргэдийн хамт ногоон тэжээл хурааж авав.




*Зураг 16 Ногоон тэжээл хурааж ургасан байдал*

## 4.2. Орон нутгийн холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдож, хашиж, хамгаалах боломжтой 1 булаг сонгож, хашиж хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх

Дорноговь аймаг Иххэт сумын 2 дугаар багийн нутагт орших Хашаатын булгийн эхийг Усны тухай хуулийн 22, 24 дүгээр зүйлд заасны дагуу Иххэт сумын байгаль хамгааллагчтай ярилцаж 40 метрийн радиуст хашиж хамгаалж хаягжуулав.




Зураг 17 Хашаатын булгийн эхийг хашиж хамгаалсан байдал

## ТАВДУГААР БҮЛЭГ: НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн нөлөөллийн бүсэд хамрагдаж байсан нэг өрхөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, тусламж үзүүлэх санал албан ёсоор гаргасан. Гэвч тухайн өрх саналыг хүлээн аваагүй бөгөөд үйлдвэрийн нөлөөллийн бүсээс нүүсэн. Иймд үйлдвэрийн нөлөөллийн бүсэд орших нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай өрх байхгүй болно.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Хөх Бишрэлт” ХХК нь түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэн ажиллахыг зорилго болгон ажилладаг. Үүний хүрээнд соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах арга хэмжээнд хувь нэмэр оруулан ажиллахыг зорьж байна.

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл одоогоор олдоогүй болно. Бид 2025 онд түүх соёлын биет болон биет бус өвийг хамгаалах арга хэмжээний хүрээнд дараах гурван ажлыг төлөвлөн хэрэгжүүллээ.

*Хүснэгт 6 Түүх соёлыг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| **№** | Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв | **Хамгаалах арга хэмжээ** | **Арга хэмжээний цар, хэмжээ** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **Биелэлт, 100 %** |
|---|---|---|---|---|---|
| **1.** | Биет бус өв | Иххэт сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өврүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх | Иххэт сум | Говийн бүсийн шагайн харваан тэмцээн болон Дорноговь аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулдаг “Морьтон Монгол”тэмцээн, Иххэт сумын наадмыг ивээн тэтгэж оролцов. | 100 % |
| 2. | Журам | Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг шинэчлэх | - | Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг боловсруулан, батлуулсан. | 100 % |
| 3 | | Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах | - | Компанийн ХАБЭА-н давтан сургалттай хамтран Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулан сургалт орсон. | 100 % |

## 6.1. Биет бус өв

### 6.1.1 Иххэт сумын ЗДТГ-тай хамтран биет болон биет бус өвс рүү чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлэх

Иххэт сумын ЗДТГ-тай хамтран Дорноговь аймгийн хэмжээнд зохион байгуулагдаг “Морьтон Монгол” арга хэмжээг 5 сая төгрөгөөр, Говийн бүсийн шагайн харваан тэмцээнийг 5сая төгрөгөөр, Иххэт сумын 101 жилийн ойн наадмыг тус тус ивээн тэтгэж оролцлоо.



ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР №344
2025 оны 09 сарын 05-ны өдөр

| Төлөгч: Хөх Бишрэлт ХХК | Дт данс | ДҮН |
|---|---|---|
| Банк: ХААН БАНК | 5166055499 | 8,000,000.00 |
| Хүлээн авагч: Эрдэнэцацрал Банк: ХААН БАНК | 5366044887 | |

Мөнгөний дүн /үсгээр/: Найман сая төгрөг мөнгө
Бараа хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн
Төлбөрийн зориулалт: Барааны болон ажил үйлчилгээний нэр, дагалдах баримтын №
5878756 Хөх бишрэлт- Өв соёл шагай
Дарга........ РЕН.ДЕВЕН
Банкинд гүйлгээ хийсэн 2025 он 9 сар 5

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР №282
2025 оны 07 сарын 30-ны өдөр

| Төлөгч: Хөх Бишрэлт ХХК | Дт данс | ДҮН |
|---|---|---|
| Банк: ХААН БАНК | 5166055499 | 5,000,000.00 |
| Хүлээн авагч: Хувьтогаалдор Банк: ХААН БАНК | 5366038432 | |

Мөнгөний дүн /үсгээр/: Таван сая төгрөг мөнгө
Бараа хүлээн авсан буюу ажил үйлчилгээ гүйцэтгүүлсэн
Төлбөрийн зориулалт: Барааны болон ажил үйлчилгээний нэр, дагалдах баримтын №
5878756- Хөх бишрэлт ХХК- Хандив
Дарга........ РЕН.ДЕВЕН
Тамга
Банкинд гүйлгээ хийсэн 2025 он 7 сар 30 өдөр тэмдэг гарын үсэг

*Зураг 18 Санхүүжилт шилжүүлсэн баримт*

## 6.2. Журам

### 6.2.1 Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг шинэчлэх

Компанийн “Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам”-ыг боловсруулан, Гүйцэтгэх захирлаар батлуулсан. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.



ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ ЖУРАМ

1. Зорилго

2. Хамрах хүрээ

3. Нэр томьёо

4. Үүрэг хариуцлага

Хуудас 1 - 4

5. Горим

6. Арга хэмжээ

Хуудас 2 - 4

*Зураг 19 Батлагдсан Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам*

### 6.1.3. Түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журмыг нийт ажилчдад танилцуулах сургалт орох. Журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах

Компанийн ХАБЭА-н давтан сургалтын үеэр тайлант жилд батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам”-ын талаар танилцуулга сургалтыг 115 хүнд явуулсан.



*Зураг 20 “Түүх соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалын талаар баримтлах журам”-н сургалт хийж буй байдал*

## ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид Жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Байгаль орчин болон баяжуулах үйлдвэрийн хэлтэс нь уурхайд ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсруулан ажиллаж түүний дагуу тавигдах шаардлагуудыг биелүүлэн ажиллаж байна.

Бид Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамнуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, устгах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Тус төлөвлөгөөний хүрээнд нийт 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тухайн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж дуусан. Биелэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт болон 7.1 -7.3-р бүлгээс харна уу.

*Хүснэгт 7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Хэрэгжилтийн товч тодорхойлолт | Биелэлт, 100 % |
|---|---|---|---|---|---|
| 1. | Үйлдвэрийн болзошгүй осол | Баяжуулах үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулах | Үйлдвэрийн талбай | Баяжуулах үйлдвэрийн 2025 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн 09 дүрээг аврах ангийн захирагчаар батлуулсан байдаг | 100 % |
| 2. | | Үйлдвэрийн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах | | Баяжуулах үйлдвэр, ажилчдын оффис, түр амрах байруудын галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас тайлант жилд гаргуулан авсан байдаг. | 100 % |
| 3. | | Үйлдвэрийн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох | | Үйлдвэрийн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, бүх барилга байгууламжийг гал унтраах, утаа мэдрэгч тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулсан. | 100 % |
| 4. | | Аюулгүй ажиллагааны хэлтэс ажлын байр, талбаруудад үзлэг хийж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх | | Аюулгүй ажиллагааны ажилтан болон үйлдвэрийн холбогдох ажилчид тогтмол ажлын байрнуудад үзлэг хийж ажиллаж байна. | 100 % |
| 5. | Химийн бодис тээвэрлэлт | Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэр луу тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, зааварчилгаа өгөх | Химийн бодисын тээвэрлэлт | ХАБЭА-н ажилтан байнгын зааварчилгаа өгдөг. | 100 % |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6. | Химийн бодисын хадгалалт | Химийн бодисыг хүлээн авахдаа сав, баглаа боодол, тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авах | Химийн бодисын агуулах | Зааврын дагуу хүлээн авсан. | 100 % |
| 7. | | Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах | | Зааврын дагуу даралтат савласан хийг хүлээн авсан. | 100 % |
| 8. | | Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээг гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах | | Баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын сав, баглаа боодолд тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд тэмдэг, тэмдэглэгээ муудсан тохиолдол тухай бүрд сольж ажилласан. | 100 % |
| 9. | | Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх | | Химийн бодисын зарцуулалт болон ашиглалтад баяжуулах үйлдвэрийн дарга, нярав нар хяналт тавьж ажилладаг. | 100 % |
| 10. | | Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх | | Химийн бодисын агуулах руу сав, баглаа боодол тээвэрлэх тохиолдол бүрд баяжуулах үйлдвэрийн ажилчид бүртгэл хөтөлж, нярав нэгтгэн ажилласан. | 100 % |
| 11. | | Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх | | Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах тусгай зөвшөөрөл бүхий “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. | 100 % |
| 12. | Галын аюул | Төслийн талбай орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох | Баяжуулах үйлдвэр | Аюулгүй ажиллагааны ажилтан нь баяжуулах үйлдвэрийн галын аюулын үзлэгийг тогтмол хэрэгжүүлсэн. Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдад гал унтраах дадлага сургалтыг тайлант жилд 2 удаа хэрэгжүүлсэн. | 100 % |

## 7.1. Үйлдвэрийн болзошгүй осол

### 7.1.1. Баяжуулах үйлдвэрийн аваар устгах төлөвлөгөө боловсруулж, холбогдох газраар батлуулах

Жонш баяжуулах үйлдвэрийн 2025 оны аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн 09 дүрээг аврах ангийн захирагч, хурандаа Д.Гантулга-аар батлуулсан байдаг.

### 7.1.2. Үйлдвэрийн барилга байгууламж бүрд галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах

Баяжуулах үйлдвэр, ажилчдын оффис, түр амрах байруудын галын дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаас тайлант жилд гаргуулан авсан байдаг.


ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0001983

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "ХӨХ БИШРЭЛТ" ХХК /5878756/

Хаяг: ДОРНОГОВЬ АЙМАГ ИХХЭТ СУМ 1-Р БАГ

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: "ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦ"

/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2/

Олгосон: 2025 он 09 сар 12 өдөр

Хүчинтэй хугацаа: 2025 он 12 сар 12 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

ДОРНОГОВЬ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

дарга ДЭД ХУРАНДАА цолтой И.ИДЭРГАРАВ

Дүгнэлт гаргасан:

ДОРНОГОВЬ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/

Гал түймрийн улсын хяналтын байцаагч ДЭСЛЭГЧ цолтой Ш.БАЯРТУВШИН

/тэмдэг дарна/

*Зураг 21 Галын аюулгүй байдлын дүгнэлт*

### 7.1.3. Үйлдвэрийн талбайд үүсэж болзошгүй аюул, эрсдэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний практик сургалтыг нийт ажилчдад орох

Үйлдвэрийн талбайд гал түймэр, онцгой байдалд эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын талбайд тогтмол ажлын байрны үзлэгүүд зохион байгуулж, бүх барилга байгууламжийг гал унтраах, утаа мэдрэгч тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулсан.

### 7.1.4. Аюулгүй ажиллагааны хэлтэс ажлын байр, талбаруудад үзлэг хийж, аливаа үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх

Баяжуулах үйлдвэрийн Аюулгүй ажиллагааны ажилтан болон үйлдвэрийн холбогдох ажилчид аюулын байр, талбаруудад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус ажлын байрны үзлэгийг тогтмол хийж ажилласан. Төлөвлөгөөт үзлэгийг 7 хоног тутам хийж байгаа бөгөөд төлөвлөгөөт бус ажлын байрны үзлэгийг өдөр тутам хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд аливаа учирч болох аюул, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг тус ажлын байр хариуцсан ажилтантай зөвшилцөн, хэрэгжилтийг хангаж ажилласан.

## 7.2. Химийн бодис тээвэрлэлт

### 7.2.1. Химийн бодисын агуулахаас бодис үйлдвэр лүү тээвэрлэхдээ асгаралтаас урьдчилан сэргийлж ажиллах, зааварчилгаа өгөх

"Хөх Бишрэлт" ХХК-ийн Баяжуулах үйлдвэрийн дарга, Аюулгүй ажиллагааны ажилтан нар химийн бодистой харьцан ажилладаг нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, тухайн өдөрт гүйцэтгэх ажлын учирч болох аливаа аюул, осол, эрсдэлийн талаар мэдээлэл өгдөг бөгөөд тухайн сөрөг нөлөөллөөс сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээг тодорхойлдог.




*Зураг 22 Аюулгүй ажиллагааны нэгдсэн зааварчилгааны тэмдэглэл*

## 7.3. Химийн бодисын хадгалалт

### 7.3.1. Химийн бодисыг хүлээн авахдаа сав, баглаа боодол, тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг шалгаж хүлээн авах

Аюулгүй ажиллагааны ажилтан нар химийн бодистой харьцан ажилладаг нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч химийн бодисын тэмдэг тэмдэглэгээний талаар зааварчилгаа өгдөг. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дотоод журамд химийн бодисын тэмдэг тэмдэглэгээний талаар оруулсан.




*Зураг 23 Хөдөлмөр аюулгүй байдлын журам аюулгүй ажиллагааны зааварчилгаа*

### 7.3.2. Даралтат савласан хийг хүлээж авах шаардлагын дагуу хүлээн авч, ашиглах нөхцөлүүдийн дагуу ашиглах

Даралтат савласан хийг аюулгүй ажиллагааны ажилтан, нярав, үйлдвэрийн дарга нар хүлээн авдаг. Хүлээн авахдаа даралтат савны гаднах хэлбэр, даралт, хавхлага, тэмдэг тэмдэглэгээ зэргийг шалгаж хүлээн авдаг бөгөөд ямарваа нэгэн гэмтэл, эвдрэл илэрсэн тохиолдолд нийлүүлэгч байгууллага руу буцааж ажилласан.

Мөн даралтат савласан хийг баяжуулах үйлдвэрийн талбайд зориулалтын хадгалах саванд байрлуулж, зөвхөн зөвшөөрөгдсөн ажилчид ашиглаж байна.

### 7.3.3. Химийн бодисын тэмдэг тэмдэглэгээг гэмтсэн салсан тохиолдолд яаралтай дахин шинэчлэн наах

Баяжуулах үйлдвэрийн ажилчид химийн бодисын сав, баглаа боодолд тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд тэмдэг, тэмдэглэгээ муудсан тохиолдол тухай бүрд сольж ажилласан.

### 7.3.4. Баяжуулах үйлдвэрт ашиглагдах химийн бодисын зарцуулалт, ашиглалтад хяналт тавих, бүртгэл хөтлөх, зарцуулалтын тайланг холбогдох байгууллага руу илгээх

Химийн бодисын зарцуулалт болон ашиглалтад баяжуулах үйлдвэрийн дарга, нярав нар хяналт тавьж ажилладаг.

### 7.3.5. Химийн бодисын сав баглаа боодлын үүсгэсэн хугацаа, тоо хэмжээ, жинг нэг бүрчлэн бүртгэх

Химийн бодисын агуулах руу сав, баглаа боодол тээвэрлэх тохиолдол бүрд баяжуулах үйлдвэрийн ажилчид бүртгэл хөтөлж, нярав нэгтгэн ажилласан. Аюултай хог хаягдлыг үүсгэсэн хугацаа, төрөл, жин болон хэмжээ тус бүрээр бүртгэн химийн бодисын агуулахад байрлуулан, хадгалж ажилласан.

### 7.3.6. Химийн бодисын сав баглаа боодлыг аюултай ачаа хүлээн авагч буюу аюултай хог хаягдал устгуулахаар холбогдох баримт бичгийг бүрдүүлэн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх

Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, устгах тусгай зөвшөөрөл бүхий “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан ажилласан.

### 7.3.7.Төслийн талбай орчимд гарч болзошгүй тал хээрийн түймэрт бэлэн байдлыг хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд гал унтраах ажилд оролцох

Аюулгүй ажиллагааны ажилтан нь баяжуулах үйлдвэрийн галын аюулын үзлэгийг тогтмол хэрэгжүүлсэн. Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдад гал унтраах дадлага сургалтыг тайлант жилд 2 удаа хэрэгжүүлсэн.

## НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бид үйл ажиллагаанаас бий болж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллахаар зорьж байна.

Бид холбогдох хууль, дүрэм, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүний дагуу хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал хэмээн ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас аюултай хог хаягдал устгах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэн ажиллахаар 2024 оны төлөвлөгөөнд тусгаж оруулсан.

Тус төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 9 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 1 арга хэмжээ хэрэгжүүлээгүй байна. Биелэлтийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгт болон холбогдох дэд бүлгүүдээс харна уу.

*Хүснэгт 8 Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| **№** | **Хог хаягдлын ангилал** | **Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ** | **Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ** | **Хэрэгжилтийн товч тодорхойлолт** | **Биелэлт, 100 %** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн | Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах, бүртгэл хөтлөх | Уурхайн хэмжээнд | Холбогдох гэрээг байгуулж байнга хамтран ажилладаг.Иххэт сумын ЗДТГ-ын даргатай 2025 оны 02-р сарын 24-ны өдөр №03 тоот гэрээ байгуулсан. | 100 % |
| 2 | | Хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих үзлэг шалгалт хийх | Уурхайн хэмжээнд | Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулж, аюултай хог хаягдлыг нийлүүлсэн. | 0 % |
| 3 | | Компанийн багц дотоод сургалтын хүрээнд нийт ажилчдад хог хаягдалтай холбоотой сургалт зохион байгуулах | Уурхайн хэмжээнд | ХАБЭА-н сургалтын дараа нийт ажилчдад сургалт орсон. | 100 % |
| 4 | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төслийн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих | Уурхайн хэмжээнд | Шаардлагатай тохиолдол бүрд хог хаягдлын тэмдэг тэмдэглэгээг сольж ажилласан | 100 % |
| 5 | Аюултай | Аюултай хог хаягдал тээвэрлэх болон устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгч акт үйлдэх | Уурхайн хэмжээнд | Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. | 80 % |
| 6 | | Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авч, бүртгүүлэх | Уурхайн хэмжээнд | Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаарыг тайлант жилд гаргуулж аваагүй тул энэхүү ажил хэрэгжээгүй. | 80 % |
| 7. | | Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх, устгалд оруулах | | Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. | 100 % |
| 8. | | Техник тоног төхөөрөмжийн ашигласан хаягдал тосыг үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тосолгоонд дахин ашиглах, тухай бүр ашиглалтын бүртгэл хөтлөх | | Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. | 100 % |
| 9. | | Үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэх, ангилан төрөлжүүлж бүртгэх, түр цэгт хадгалах, устгах үйлдвэрт нийлүүлэх | | Элемент ХХК-тай Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах гэрээ байгуулсан. | 100 % |
| 10. | | Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлнэ | | Иххэт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид БОХ тайланг хүргүүлсэн. | 100 % |

## 8.1. Ахуйн хог хаягдал

### 8.1.1. Ахуйн буюу дахин ашиглах боломжгүй энгийн хог хаягдлыг сумын төвлөрсөн хогийн цэгт нийлүүлэх гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах, бүртгэл хөтлөх

Холбогдох гэрээг байгуулж байнга хамтран ажилладаг. Иххэт сумын ЗДТГ-ын даргатай 2025 оны 02-р сарын 24-ны өдөр №03 тоот гэрээ байгуулсан.



БАТЛАВ:
"ХӨХ БИШРЭЛТ" ХХК-НИЙ
ЗАХИРАЛ
РЕН ДЕВЕН

БАТЛАВ:
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.СОДМАГНАЙ

"ХӨХ БИШРЭЛТ" ХХК БОЛОН
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН ЗДТГ -ТАЙ
"ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ" ГЭРЭЭ

№03

2025 оны 02 сарын 24-ний өдөр Зүлэгт

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго нь Дорноговь аймгийн Иххэт сумын нутаг дэвсгэрт Ашигт малтмал ашиглаж олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахдаа, тус сумын хөгжилд тодорхой дэвшил үзүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэн, ажлын байрны болон орчны бохирдол, хог хаягдлыг хууль журамд нийцүүлэн зайлуулах, хамтран ажиллахад оршино.
1.2 Нэг талаас "ХӨХ БИШРЭЛТ" ХХК-ийг төлөөлж үйлдвэрийн дарга Ц.Ариунцэцэг, нөгөө талаас Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ /цаашид ЗДТГ/-ыг төлөөлж, Байгаль орчны бодлогын мэргэжилтэн М.Ганбат нар харилцан тохиролцож энэхүү гэрээг доорхи нөхцлөөр байгуулав.
1.3 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгдөнө.

ХОЁР: "ИХХЭТ СУМЫН ЗДТГ-ЫН
ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

2.1 "Иххэт" сумын ЗДТГ нь шаардагдах үйлчилгээ, дэмжлэгийг үзүүлэх.
2.2 "Иххэт" сумын ЗДТГ нь шаардагдах үйлчилгээ, дэмжлэгийг хууль тогтоомжид нийцүүлэн, гэрээнд заасны дагуу үзүүлнэ.
2.2 Уурхайн орчныг бохирдолгүй байлгах, хог хаягдлыг тогтсон хуваарийн дагуу цэвэрлэж, орчныг эрүүл байлгах нөхцлийг бүрдүүлэх, хангахыг шаардах эрхтэй.
2.3 Хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд шаардлага тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.

ГУРАВ: "ХӨХ БИШРЭЛТ" ХХК-НИЙ ЗҮҮН ЦАГААН ДЭЛИЙН
БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 Уурхайн ойр орчим, эзэмшлийн талбайг бохирдолгүй байлгах, түр хадгалах цэгүүд байршуулах, тогтсон хуваарийн дагуу хог хаягдал ачиж зайлуулахад шаардлагатай нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.
3.2 Хог хаягдлын тухай хууль, холбогдох журмын дагуу төлбөр, хураамжийг цаг хугацаанд нь төлөх.
3.3 Хог хаягдлын төлбөрийг, Дорноговь аймгийн Иххэт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 05/08 дугаартай тогтоолын хавсралт /Уулын үйлдвэрийн хог хаягдлын үйлчилгээний хураамж/-д заасан төлбөрийн дагуу 1 сард 30,000 /гучин мянга/ төгрөгийг, Төрийн сан банкны 100060500947 тоот дансанд 1 жилээр тооцон 360,000 /гурван зуун жаран мянга/ төгрөгийг сар бүрийн 20-ны өдрийн дотор шилжүүлнэ.
3.4 Сумын төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг булшлах ажилд хамтран ажиллах. /Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу/

ДӨРӨВ: ХАМТРАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

4.1 Энэхүү гэрээг биелүүлэхэд 2 тал санаачлага гаргаж ажиллана.
4.2 Талууд албан бичгийн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
4.3 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарах, эсхүл цуцлах тохиолдолд талууд бие биедээ албан бичгээр мэдэгдэнэ.

ТАВ: ГЭРЭЭГ ДҮГНЭХ

5.1 Энэхүү гэрээний биелэлтийг, гэрээний үйлчлэх хугацаа дуусахаас өмнө буюу ажлын 10 хоногт багтаан 2 тал хамтран дүгнэнэ.
5.2 Гэрээний биелэлтийг хангалттай, хангалтгүй гэсэн үзүүлэлтээр дүгнэнэ.
5.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлснээс үүдэн нөгөө талд ямар нэгэн хохирол учирсан бол буруутай тал нь нөгөө талын хохирлыг барагдуулах үүрэгтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"ХӨХ БИШРЭЛТ" ХХК-НИЙ
ҮЙЛДВЭРИЙН ДАРГА
Ц.АРИУНЦЭЦЭГ
Утас: 99153477

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ
СУМЫН ЗДТГ-ЫН БОБМЭРГЭЖИЛТЭН
М.ГАНБАТ
Утас: 95545559

*Зураг 24 Хог хаягдлын гэрээ*

### 8.1.2. Хог хаягдлын ангилан ялгалтад хяналт тавих үзлэг шалгалт хийх

Баяжуулах үйлдвэрийн үйлчилгээ, цэвэрлэгээний ажилчид, үйлдвэрийн дарга нар сар тутам хог хаягдлын ангилан ялгалт, ил задгай хог хаялт, хог хаягдлын савны үзлэгийг хийж ажиллаж байна. Тайлант жилд анхаарал татахуйц зөрчил илрээгүй бөгөөд тэмдэг тэмдэглэгээ муудсан зэрэг илэрсэн зөрчлийг нэн даруй арилган ажилласан.



*Зураг 25 ангилан ялгах хогийн сав*

### 8.1.3. Компанийн багц дотоод сургалтын хүрээнд нийт ажилчдад хог хаягдалтай холбоотой сургалт зохион байгуулах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн давтан сургалтыг ХАБЭА-н ажилтан өгөх үеэр хог хаягдлын ангилан ялгалт, хог хаягдлын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтыг зохион байгуулсан.




*Зураг 26 Сургалт орж буй байдал*

### 8.1.4. Төслийн талбайд байрлах бүх хогийн савны тэмдэг тэмдэглэгээ муудсан тохиолдолд тухай бүрд солих

Баяжуулах үйлдвэрийн үйлчилгээ, цэвэрлэгээний ажилчид, үйлдвэрийн дарга нар сар тутам хог хаягдлын ангилан ялгалт, ил задгай хог хаялт, хог хаягдлын савны үзлэгийг хийж ажиллаж байна. Тухайн үзлэгээр тэмдэг тэмдэглэгээ муудсан зэрэг илэрсэн зөрчлийг нэн даруй арилган ажилласан.



*Зураг 27 ангилан ялгах хогийн савны тэмдэг тэмдэглэгээ*

## 8.2. Аюултай хог хаягдал

### 8.2.1. Аюултай хог хаягдал тээвэрлэх болон устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгч акт үйлдэх

Химийн бодисын агуулахад аюултай хог хаягдлыг байрлуулан ажиллаж байна. Химийн бодисын агуулах руу зөөж байрлуулсан аюултай хог хаягдлыг үйлдвэрийн нярав тухай бүр төрөл тус бүрээр, ширхэг болон жин хэмжээгээр тэмдэглэн хөтөлж байна.



*Зураг 28 Аюултай хог хаягдлын акт*



*Зураг 29 Аюултай хог хаягдал тээвэрлэх үеийн зураг*

### 8.2.2. Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаар авч, бүртгүүлэх

Аюултай хог хаягдал үүсгэгчийн дугаарыг тайлант жилд гаргуулж аваагүй тул энэхүү ажил хэрэгжээгүй.

### 8.2.3.Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх, устгалд оруулах

“Элемент” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр “Химийн хортой болон аюултай бодисын, устгах ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан Тайлант жилд нийт химийн бодисын хуванцар сав 385 ширхэг, сав баглаа боодол 2100 кг тус тус устгалд оруулсан байна




*Зураг 30 Аюултай хог хаягдлын гэрээ*

### 8.2.4. Техник тоног төхөөрөмжийн ашигласан хаягдал тосыг үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тосолгоонд дахин ашиглах, тухай бүр ашиглалтын бүртгэл хөтлөх

Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. Тайлант жилд хөнгөн тэрэг, техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс үүссэн нийт тос, тосолгооны материалыг үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийн тосолгоонд дахин ашигласан болно.

### 8.2.5. Үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлыг цэвэрлэх, ангилан төрөлжүүлж бүртгэх, түр цэгт хадгалах, устгах үйлдвэрт нийлүүлэх

Химийн бодисын агуулахад аюултай хог хаягдлыг байрлуулан ажиллаж байна. Химийн бодисын агуулах руу зөөж байрлуулсан аюултай хог хаягдлыг үйлдвэрийн нярав тухай бүр төрөл тус бүрээр, ширхэг болон жин хэмжээгээр тэмдэглэн хөтөлж байна.

### 8.2.6. Үйл ажиллагаанаас гарсан нийт хог хаягдал болон дахин ашигласан хог хаягдлын хэмжээг тогтмол бүртгэж, БОХ тайланд тусгаж сумын захиргаанд хүргүүлнэ

Иххэт сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид БОХ тайланг хүргүүлэхээр төлөвлөн боловсруулалтын ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайн арга хэмжээг тайлант жилд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөж байна

## ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Бид төлөвлөгөөт жилд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд нийт 7 төсөвт болон төсөвт бус арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүллээ.

*Хүснэгт 9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | | Хэрэгжилт | Биелэлт, % |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөх үйлчилгээний ААН-тэй гэрээлэх | Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран үйлдвэрийн нийт ажилчдад сургалт зохион байгуулсан. | 100 % |
| 2 | | Үйлдвэрийн БОННҮ нэмэлт тодотгол мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хийлгэх | БОННҮ нэмэлт тодотголын ажил гэрээ байгуулснаар боловсруулалтын ажил явагдаж байгаа | 100 % |
| 3 | Ногоон байгууламж | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн хашаан дотор модны суулгац тарих | Хэрэгжүүлж ажилласан | 100 % |
| 4 | | Баяжуулах үйлдвэр дээр тарьсан мод, бутлаг ургамлын ургалт, өсөлт, ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжлийн модны мэргэжилтэн зөвлөгөө авч, хамтран ажиллах | Холбогдох мэргэжилтний зөвөлгөө авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | 80% |
| 5 | Бичиг баримт | Төслийн ус ашиглах дүгнэлт авах, гэрээ байгуулан ажиллах | Холбогдох дүгнэлтийг гаргуулж гэрээ байгуулсан | 100 % |
| 6 | | Төслийн хаягдал усны дүгнэлт авах, гэрээ байгуулах, зөвшөөрөл авах, холбогдох төлбөрийг төлөх | Дүгнэлт гарсан, төлбөрийг хийсэн | 100 % |
| 7 | Орон нутаг, хамтын ажиллагаа | Орон нутагтай хамтран ажиллах гэрээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдэд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах | Хамтран ажиллах гэрээний дагуу ажлуудыг хэрэгжүүлж дууссан | 100 % |

## 9.1 Зөвлөх үйлчилгээний ААН-тэй гэрээлэх

### 9.1.1 Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран үйлдвэрийн нийт 76 ажилчдад сургалт зохион байгуулсан.




*Зураг 31 ХАБЭА-н сургалт*



ХАБЭА- н 2025 оны нийт ажилтны сургалтын бүртгэл

*2025 оны 6 дугаар сарын 2 ны өдөр*

| | Овог | Нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | | РенДвен | Захирал | |
| 2 | Цогзол | Ариунцэцэг | Үйлдвэрийн дарга | |
| 3 | Эгүүний | Нандинцэцэг | Үйлдвэрийн дарга | |
| 4 | Жаргалсайхан | Ариунжаргал | Нягтлан | |
| 5 | Мөнхжаргал | Мөнхзул | Хүний нөөц | |
| 6 | Алтантуяа | Бөхбат | ХАБЭА | |
| 7 | Тогоодарь | Уянга | ХАБЭА | |
| 8 | Лэгшид | Пүрэвсүрэн | Нярав | |
| 9 | Ариунзаяа | Оюунцэцэг | Нярав | |
| 10 | Ганболд | Одгариг | Менежер | |
| 11 | Пүрэвсүрэн | Хишигсүрэн | Менежер | |
| 12 | Чимэдцэеэ | Аюушжав | Менежер | |
| 13 | Өөж | Гантөмөр | Ээлжийн мастер | |
| 14 | Бохан | Жаньбек | Ээлжийн мастер | |
| 15 | Г | Баянжаргал | Ээлжийн мастер | |
| 16 | Баттөмөр | Батцэцэг | тогооч | |
| 17 | Отгонхишиг | Учрал | тогооч | |
| 18 | Эрдэнэ | Ангилмаа | тогооч | |
| 19 | Чулуунбаатар | Сэлэнгэ | Пүүлэгч, талбай зохион байгуулагч | |
| 20 | Наранчимэг | Ууганбаяр | Оператор | |
| 21 | Бат-Эвлэл | Бат-Од | Оператор | |
| 22 | Бадиваа | Амарсанаа | Оператор | |
| 23 | Мөнхжаргал | Мөнхбаяр | Оператор | |
| 24 | Тогтохбаяр | Мөнхномин | Оператор | |
| 25 | Буян-Өлзий | Наранбаяр | Оператор | |
| 26 | Эрдэнэчимэг | Энхбаяр | Оператор | |
| 27 | Отгонмаам | Азжаргал | Оператор | |
| 28 | Төмөрбаатар | Сайханбаатар | Оператор | |
| 29 | Бямбаа | Алтанөлзий | Оператор | |
| 30 | Хүрэлбаатар | Энхманлай | Оператор | |
| 31 | Бэх-Очир | Мэндбаяр | Оператор | |
| 32 | Батсэнгэ | Мөнгөнсоёл | Оператор | |
| 33 | Ундралмаа | Болдмаа | Лаборант | |
| 34 | Батсэнгэ | Мөнгөнэрдэнэ | Лаборант | |
| 35 | Дашдондог | Энхзул | Лаборант | |
| 36 | Баттуяа | Наранчимэг | Лаборант | |
| 37 | Хүүхэнхүү | Угандулам | Лаборант | |
| 38 | Бадиваа | Ариунсанаа | Баяжуулагч | |
| 39 | Ёндонпил | Нарангэрэл | Тээрэмчин | |
| 40 | Ундралмаа | Дэжидханд | Шүүгч | |
| 41 | Ганболд | Эрдэнэтогтох | Шүүгч | |
| 42 | Шагдар | Наранчимэг | Лаборант | |
| 43 | Батмөнх | Ууганбаяр | Бутлуурчин | |
| 44 | Гантөмөр | Гангэрэл | Бутлуурчин | |
| 45 | Ганболд | Жанцан | Бутлуурчин | |
| 46 | Чадраабал | Чулуунсүх | Бутлуурчин | |
| 47 | Мөнх-Очир | Мөнхбат | Бутлуурчин | |
| 48 | Хүүхэнхүү | Баярсайхан | Бутлуурчин | |
| 49 | Нэмэхбаяр | Бат-Отгон | Бутлуурчин | |
| 50 | Дашдаваа | Ганбаатар | Бутлуурчин | |
| 51 | Ганболд | Баянжаргал | | |
| 52 | Батсайхан | Булгантамир | Шүүгч | |
| 53 | Эрдэнэтогтох | Анубилгүүт | Шүүгч | |
| 54 | Халтар | Болд | Савлагч | |
| 55 | Цэнд-Очир | Золжаргал | Савлагч | |
| 56 | Хад | Өнөрцэцэг | Савлагч | |
| 57 | Цэдэвсүрэн | Гансүх | Савлагч | |
| 58 | Отгонбаатар | Цэрэн | Савлагч | |
| 59 | Цэдэнжав | Отгонбилэг | Засварчин | |
| 60 | Бадамсүрэн | Энхбаатар | Тээрэмчин | |
| 61 | Тапи | Күнтуган | Уурын зуух | |
| 62 | Тунгалаг | Лхавгадорж | Савлагч | |
| 63 | Батбаяр | Энхжаргал | Тээрэмчин | |
| 64 | Баттогтох | Батэрдэнэ | Савлагч | |
| 65 | Бямбаа | Энхамгалан | | |
| 66 | Буххүү | Батбаяр | Уурын зуух | |
| 67 | Санпилдэндэв | Нармандах | Усан сан | |
| 68 | Цэдэн-Иш | Энхбаяр | | |
| 69 | Төмөрбаатар | Өсөхжаргал | Жолооч | |
| 70 | [illegible] | | | |
| 71 | [illegible] | [illegible] | Тогооч | |
| 72 | [illegible] | [illegible] | Тогооч | |
| 73 | [illegible] | | [illegible] | |
| 74 | [illegible] | | | |
| 75 | [illegible] | [illegible] | [illegible] | |
| 76 | [illegible] | [illegible] | [illegible] | |
| 77 | | | | |
| 78 | | | | |
| 79 | | | | |
| 80 | | | | |
| 81 | | | | |
| 82 | | | | |
| 83 | | | | |
| 84 | | | | |
| 85 | | | | |
| 86 | | | | |
| 87 | | | | |
| 88 | | | | |
| 89 | | | | |
| 90 | | | | |
| 91 | | | | |
| 92 | | | | |
| 93 | | | | |
| 94 | | | | |
| 95 | | | | |

*Зураг 32 ХАБЭА-н сургалт авсан бүртгэл*

### 9.1.2 Үйлдвэрийн БОННҮ нэмэлт тодотгол мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хийлгэх

БОННҮ нэмэлт тодотголыг мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулан хийлгэж иргэдийн нийтийн хурлын тогтоол баталгаажаагүй хүлээж байна.



ДОРНОГОВЬ АЙМАГ ИХХЭТ СУМЫН 1 ДҮГЭЭР БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС ...

2025.10.06 Дугаар 04 Бүрдэнэ

Дорноговь аймгийн Ихххэт сумын 1 дүгээр багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаан 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 14 цаг 20 минутанд Бүрдэнэ багийн төвд хуралдав.

Хурлын ирц 82 өрхийн 87 хүн ирж, ирц бүрдсэн тул хуралдааныг БИНХ-ын хуралдааны дарга С.Алтанбагана нээж эхлүүлэв.

Хуралдаанд урилгаар сумын Засаг дарга Б.Содмагнай, Газрын даамал Г.Батсүх " Хөх бишрэлт " ХХК-ны Дотоод хяналтын ажилтан Э.Нандинцэцэг, нягтлан Ж.Ариунжаргал нар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

5. Хөх бишрэлт ХХК-ны 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, Сумын засаг даргатай нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн гэрээний биелэлтийн талаар танилцуулах

**С.Алтанбагана:** Хэлэлцэх асуудалтай холбоотой асуух асуулт байна уу?
Асуулт байхгүй тул асуултаа таслах уу?
Иргэд 100%-ийн саналаар асуултаа тасаллаа.
Хэлэлцэх асуудалтай холбоотой санал дүгнэлт хэлэх хүн байна уу?
Санал дүгнэлт хэлэх хүн байхгүй тул санал дүгнэлтийг 100%-аар таслав.
Хэлэлцэх асуудлаа батлах уу?
Хуралдаанд оролцсон иргэдийн 100%-ийн саналаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг батлав.

5.ХЭЛЭЛЦСЭН НЬ:

**С.Алтанбагана:** "Хөх бишрэлт " ХХК-иас 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан гэрээний биелэлтийн талаар танилцуулна.

**Э.Нандинцэцэг:** Багийн ахмадуудад ахмадын баярын мэнд хүргэе. Тухайн компани нь 2025 ондоо байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө тусгаад хийгдсэн ажлаас та бүгдэд танилцуулахад орон нутагт олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж компаниас сумын төв орох, Бор-Өндрийн хуссан замд нийлэх салаа замуудад тэмдэг тэмдэглэгээ байршуулсан, тоосжилтоос сэргийлж бороо хур багатай үед 14 хоногт 1 удаа усны машинаар компаний хашаан дотор болон гадна 500 м-ийн зайд усалгаа хийсэн нийт 6 сараас 9 сарыг дуустал хугацаанд 8 удаа хийсэн, 7 сард сумын төвийн гэр байр, наадмын талбайд 3 удаа усалгаа хийсэн. Мөн сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг хавар 4 сард, намар 10 сард хогийг түрж булшилж өгсөн, 10,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 1 булаг сэргээн засварлаж хашаажуулсан. / 2-р баг Өврийн Зүлэгтийн булаг /, нүүлгэн шилжүүлэх зардаар 1-р багийн иргэн Я.Нямаад 10,0 сая төгрөгийн зардал гарсан, Өв соёлын зардлаас шагайн харвааны бүсийн Болорын тойрмын харваанд 10,0 сая төгрөг, бүсийн адуучин тэмцээнд 5,0 сая төгрөг, сумын баяр наадамд 5,0 сая төгрөг хандивласан. Дүйцүүлэн нөхөн сэргээх аргаар Идэвхтэн байгаль хамгаалагчаар ажиллаж байгаа 1-р багийн иргэн С.Алтанхуяг болон багийн 3 залуутай хамтран хууль бус аргаар өнгөт чулуу түүж эвдэгдсэн газарт 5 га газрыг хашаажуулан ногоон тэжээлийн үр худалдан авч өгч тариалалт хийлгэсэн талаар ярьж танилцуулсан.

**Хөх бишрэлт ХХК-ны нягтлан Ж.Ариунжаргал :**

Сумын засаг даргатай хамтарн ажиллах гэрээний дагуу 1-р багийн 5 малчныг тус бүр 6,0 сая төгрөгөөр мал худалдан авахад дэмжлэг үзүүлсэн, 1-р багийн 1, 2-р багийн 1 нийт 2 оюутаны сургалтын төлбөр нийт 7818,0 сая төгрөг төлсөн. Сумын идэвхтэн байгаль хамгаалагч С.Алтанхуягт сар бүр 1,0 сая төгрөгийн урамшуулал олгож байна. 2025 оны 1-9 сарын нийгмийн даатгалд 563,0 сая, цалингийн суутган / ХАОАТ / 69,6 сая төгрөг, ус ашигласаны төлбөр 99,0 сая төгрөг, ус бохирдуулсаны төлбөр 2,7 сая төгрөг тус тус төлөөд байгаа талаар танилцуулсан.

**Пүрэвжав:** Багийн малчдыг малжуулахад ямар шалгуураар өгдөг вэ. Хамар уснаас компани хүртлэх замыг дахин засварлах уу.

Хариулт :

**Э.Нандинцэцэг:** Мал авахад нь дэмжлэг болж байгаа малчид, оюутаны төлбөр төлүүлж байгаа айл өрхийг танай багийн зөвлөл хуралдаад нэрсийг нь өгсөн. Бас сумын ЗДТГ-ын мэргэжилтэн, багийн дарга нар гэрээ хийсэн. Замын асуудлыг 10-р сардаа дахин засна энэ жил манай компани тээвэр хийгээгүй гэхдээ зуны их бороонд эвдэгдсэнийг зассан сумын иргэд хөдөлгөөнд оролцож байгаа тул машин тэрэг явахад их хүндрэлтэй байдаг.

**Д.Мөнхцэцэг :**Багийн малгүй болсон малчдыг ажилд авдаг уу.

**Э.Нандинцэцэг:**

Ажлын байрны орон тоо гарсан цагт орон нутгаасаа боломжоор нь ажилд авдаг. Танай багийн малгүй болоод төвд орсон 4 залуу ажилд орсон. Бас нэмж хэлэхэд хөдөөнөөс ажилд орж байгаа залуучууд маань цаг барьдаггүй дуртай үедээ ажилдаа ирдэг адуу малаа харна гээд ажлын байрыг шууд орхиод явах гэх зэрэг дутагдалтай тал их байна.

*Зураг 33 Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл*

## 9.2. Ногоон байгууламж

### 9.2.1 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн хашаан дотор модны суулгац тарих

“Хөх бишрэл” ХХК тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд үйлдвэрийн талбайн ногоон байгууламжид нийт 800 шиохэг мод тарьсан. Уг ажлын хүрээнд 300 ширхэг шар хуайс, 500 ширхэг зэргийг мод үржүүлгийн газраас худалдан авч тарьж арчлалтыг хийж байна.



*Зураг 34 Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарьж буй байдал*

### 9.2.2 Баяжуулах үйлдвэр дээр тарьсан мод, бутлаг ургамлын ургалт, өсөлт, ирээдүйд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжлийн ойжуулалтын инженерээс зөвлөгөө авч, хамтран ажиллах

Жимс ногооны агрономич, хөдөө аж ахуй ухааны доктор Б.Дорждэрэмтэй зөвлөх үйлчилгээ авах ажил гэрээ хэлэлцээрийн шатанд явж байгаа.

## 9.3 Орон нутаг, хамтын ажиллагаа

### 9.3.1. Орон нутагтай хамтран ажиллах гэрээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх арга хэмжээнүүдэд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах

Дорноговь аймгийн Иххэт сумын ЗДТГ болон идэвхтэн байгаль хамгаалагч нартай хамтарч “ХУСТАЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР”-ийн Тариатын ам гэдэг газраас 50 тооны монгол тарвага 2025 оны 07 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд барив. Үүнээс эрэгчин 22, эмэгчин 24, мөндөл 4.-ийг Иххэт сумын нутаг сэргээн нутагшуулах талбайд хүлээлгэ өгөв. Нутагшуулах үед биеийн байдлыг тэмдэглэн үлдээв.


8/15/25, 9:42 AM

Иххэт акт_2025.jpeg

"ХУСТАЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР" ТӨВ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА АМЬТАН ХҮЛЭЭЛЦЭХ БАРИМТ

Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах зорилгоор "Сайн санаат хүмүүсийн санаачилгаар" Дорноговь аймгийн "Их Хэт сумын нутаг"-т 50 тооны монгол тарвага шилжүүлэн сэргээн нутагшуулахаар Хустайн байгалийн цогцолборт газрын Тариатын ам гэх газраас 50 тооны монгол тарвага 7-р сарын 01-ний өдрөөс 7-р сарын 5-ны өдөрт барив. Үүнээс эрэгчин 22 , эмэгчин 24, мөндөл 4.

Хустайн байгалийн цогцолборт газраас монгол тарвага тээвэрлэх үеийн эрүүл мэндийн байдал:

Өвчлөл гэмтэл, биеийн байдал муудсан шинж тэмдэг үгүй, цовоо сэргэлэн байв.

Их Хэт сумын нутаг, сэргээн нутагшуулах талбайд монгол тарвага суллах үеийн эрүүл мэндийн байдал:

Тээвэрлэлтийн явцад аливаа өвчлөл гэмтэл, биеийн байдал муудсан шинж тэмдэг үгүй, цовоо сэргэлэн тээвэрлэгдэж сэргээн нутагшуулах талбайд хүрч нутагшуулсан

"Хустайн цогцолборт газар" төв байгаль орчны мэргэжлийн байгууллагаас хариуцан ажиллаж, хүлээлгэн өгч, баримтжуулсан:

ЗАХИРАЛ: / Ц.ДАШПҮРЭВ /

/ Г.УУГАНБАЯР /

/Судлаач, Хамгааллалтын менежер/

"Дорноговь аймгийн Их Хэт сум"-ыг төлөөлж хүлээн авсан:

2025 оны 7-р сарын 6-ны өдөр


“ХУСТАЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР” ТӨВ

“ДОРНОГОВЬ АЙМГИЙН ИХХЭТ СУМЫН НУТАГ, БАЯН-УУЛ ХАЙРХАНД” МОНГОЛ ТАРВАГА (*Marmota sibirica* Radde, 1862) СЭРГЭЭН НУТАГШУУЛСАН ТАЙЛАН

*Гэрэл зураг: Хустайн БЦГ-т газрын монгол тарваганы зодоон*

ТАЙЛАН ХЯНАСАН: *Ц.ДАШПҮРЭВ ©*
*"Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга*

ТАЙЛАН БИЧСЭН: *Магистр Г.УУГАНБАЯР ©*
*"Хустайн байгалийн цогцолборт газрын амьтны биологич*

*Бакалавр А.ГЭГЭЭ ©*
*"Хустайн байгалийн цогцолборт газрын ургамлын биологич*

2025 он

*Зураг 35 амьтан нутагшуулах тайлан, хүлээлцэх баримт*



*Зураг 36 Иххэт сумын Баян-Уул хайрханы орчимд тарвага сэргээн нутагшуулж байна*

## АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч Хөх Бишрэлт ХХК нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүн, гэрээт компанийн тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

*Хүснэгт 10 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | **Арга хэмжээний цар, хэмжээ** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **Биелэлт, 100 %** |
|---|---|---|---|---|
| **1.** | Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд ус, хөрс, агаар, ургамал, амьтны дээжлэлт, хэмжилт, шинжилгээ хийх хяналтын цэгүүдийн байршлыг тодорхойлох, тухайн цэгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, кодлох болон дугаарлалтын систем бий болгох | Баяжуулах үйлдвэр | Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд авч буй ус, хөрс, агаарын дээжлэлт болон хэмжилтийг тухайн байршлын ойр орчимд байрлах үйлдвэрийн обьектын нэршлээр нэрлэн, мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. | 100 % |
| 2. | Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар гүйцэтгэх, үр дүнг боловсруулах | Баяжуулах үйлдвэр | Хуваарийн дагуу хэмжилтүүдийг тогтмол хэрэгжүүлж ажилласан. Хэмжилтийн үр дүнд холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй. | 100 % |
| 3. | Хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх | Баяжуулах үйлдвэр | Хуваарийн дагуу дээжлэлтийг тогтмол хэрэгжүүлж ажилласан. Лабораторийн шинжилгээний үр дүнд холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй. | 100 % |
| 4. | Ундны усны дээж авч химийн болон бактерийн үзүүлэлтийг шинжлүүлэх | Баяжуулах үйлдвэр | Хуваарийн дагуу дээжлэлтийг тогтмол хэрэгжүүлж ажилласан. Лабораторийн шинжилгээний үр дүнд холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй. | 100 % |

**10.1 Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд ус, хөрс, агаар, ургамал, амьтны дээжлэлт, хэмжилт, шинжилгээ хийх хяналтын цэгүүдийн байршлыг тодорхойлох, тухайн цэгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, кодлох болон дугаарлалтын систем бий болгох**

Орчны хяналт шинжилгээний арга хэмжээний хүрээнд авч буй ус, хөрс, агаарын дээжлэлт болон хэмжилтийг тухайн байршлын ойр орчимд байрлах үйлдвэрийн обьектын нэршлээр нэрлэн, мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна. Ингэснээр дараа дараагийн хяналт шинжилгээний ажилд цэгийн байрлалыг олоход тустай гэж үзэж байна.

**10.2 Агаарын хэмжилтийг зөөврийн багажаар гүйцэтгэх, үр дүнг боловсруулах**

Хуваарийн дагуу хэмжилтүүдийг тогтмол хэрэгжүүлж ажилласан. Хэмжилтийг Цаг уур, орчны шинжилгээний газрын Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторитой хамтран хэрэгжүүлсэн. Хэмжилтийн үр дүнд холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй.




*Зураг 37 Агаарын хэмжилт болон үр дүн*

## 10.3 Хөрсний дээжлэлтийг гүйцэтгэж лабораториудад харгалзах үзүүлэлтүүдээр шинжлүүлэх

Хуваарийн дагуу дээжлэлтийг тогтмол хэрэгжүүлж ажилласан. Хөрсний дээжийг Монгол улсад магадлан итгэмжлэгдсэн лаборатори болох “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн. Лабораторийн шинжилгээний үр дүнд холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй.



“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836

№ 25/03-31/1

Захиалагч: **“Хөх бишрэлт” ХХК**
Дээж авсан цэг: **“Хөх бишрэлт” байжуулах үйлдвэр, Дорноговь аймаг, Иххэт сум**
Сорьц авсан огноо: **2025 оны 03 сар 27 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **03 сарын 31**

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох суурьнууд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_2O_5$ | $K_2O$ |
| Бутлуурын ойролцоо | | | | | | | | | | | |
| 1 | 0-20 | 8.24 | 0.115 | 0.279 | 0.67 | 0.32 | 1.08 | 9 | 14 | 0.8 | 5 |
| Уурын зуух ойролцоо | | | | | | | | | | | |
| 2 | 0-20 | 8.70 | 0.036 | 0.087 | 1.69 | 0.32 | 0.29 | 10 | 10 | 0.4 | 5 |
| Химийн бодисын агуулах | | | | | | | | | | | |
| 3 | 0-20 | 9.19 | 0.038 | 0.093 | 0.83 | 0.6 | 0.31 | 10 | 11 | 0.8 | 5 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Бутлуурын ойролцоо | | | | | | | | |
| 1 | 0-20 | 10.7 | 57.5 | 12.8 | 9.8 | 3.4 | 5.8 | 19.0 |
| Уурын зуух ойролцоо | | | | | | | | |
| 2 | 0-20 | 11.6 | 64.2 | 11.8 | 7.6 | 1.2 | 3.6 | 12.4 |
| Химийн бодисын агуулах | | | | | | | | |
| 3 | 0-20 | 16.7 | 52.3 | 11.4 | 8.4 | 4.3 | 6.9 | 19.6 |

3. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Бутлуур | 0-20 | 33.4 | 50.1 | 0 | 100.3 | 16.8 | 15.8 |
| Зуух | 0-20 | 25.0 | 27.5 | 0 | 77.8 | 14.6 | 12.1 |
| Химийн бодисын агуулах | 0-20 | 8.4 | 17.5 | 0 | 64.3 | 13.0 | 12.5 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

*Харгалзах түвшин   * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг галын дөрсөнд атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.ҮҮГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, УЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail:

№ 25/03-31

Захиалагч: **“Хөх бишрэлт” ХХК**
Дээж авсан цэг: **Дорноговь аймаг Их хэт сум**
Сорьц авсан огноо: **2025 оны 03 сар 27**
Уст цэгийн төрөл: **худаг**
Зориулалт: унд ахуй
Харилцах утас:
Аргын стандарт: **MNS1097:1970**

| Катион | 1 дм³ | | | Анион | 1 дм³ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг/л | мг-экв/л | мг-экв/% | | мг/л | мг-экв/л | мг-экв/% |
| $Ca^{++}$ | 46.00 | 2.30 | 37.25 | $CO_3^{--}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $Mg^{++}$ | 34.00 | 2.80 | 45.39 | $HCO_3^-$ | 264.00 | 4.33 | 70.25 |
| Fe | 0.00 | 0.00 | 0.00 | $Cl^-$ | 48.00 | 1.35 | 21.98 |
| $K^+$ | 1.00 | 0.03 | 0.42 | $SO_4^{--}$ | 16.00 | 0.33 | 5.41 |
| $Na^+$ | 24.00 | 1.04 | 16.94 | $NO_3^-$ | 9.00 | 0.15 | 2.36 |
| **Дүн** | **105.00** | **6.16** | **100.00** | **Дүн** | **337.00** | **6.16** | **100.00** |

Анион катионуудын нийлбэр:
$(\sum_{A-K})$ **442 мг/л**
$HCO_3$ ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: **310 мг/л**
***Физик үзүүлэлтүүд***
Өнгө: 0-**өнгөгүй**
Үнэр: 0-**үнэргүй**
Булингар: **Булингаргүй**
Тунгалаг: **Тунгалаг**

Хуурай үлдэгдэл, мг/л: **263 ppm**
Ерөнхий **хатуулаг: 5.10 мг-экв/л**
*(бага хатуулагтай ус)*
Урвалын орчин: pH- **7.78**
Цахилгаан дамжуулах чадвар:
EC **-0.617 ds/m**
TDS: **0.302 ppm**

$$M(0.44) = \frac{HCO3\ 70\ [Cl\ 22\ SO4\ 5]}{Mg\ 45\ Ca\ 37\ [Na\ 17]}$$

***Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, магнийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус.***

*Жич: усны сорьцыг шинжлүүлэгч байгууллага хүрч ирж хариуцан гүйцэтгэсэн болно.*

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: С.НЯМДАШ MSc
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.

*Зураг 38 Хөрсний дээжлэлтийн лабораторийн шинжилгээний хариу*

## 10.4 Ундны усны дээж авч химийн болон бактерийн үзүүлэлтийг шинжлүүлэх

Хуваарийн дагуу дээжлэлтийг тогтмол хэрэгжүүлж ажилласан. Усны дээжийг Монгол улсад магадлан итгэмжлэгдсэн лаборатори болох “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн. Лабораторийн шинжилгээний үр дүнд холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн үзүүлэлт гараагүй.

## АРВАН НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатанд орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж, нээлттэй байх, хамтран ажиллах зарчмыг “Хөх Бишрэлт” ХХК баримтан ажиллана.

2025 онд бид нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээний хүрээнд доорх арга хэмжээнүүдийг төлөвлөв.

*Хүснэгт 11 Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөөний биелэлт*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Цар хүрээ | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | Биелэлт, 100 % |
|---|---|---|---|---|
| 1. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах | Иххэт сумын ИНХ | 2025 оны 10-р сарын 6-ний өдөр зохион байгуулагдсан Иххэт сумын Бүрдэнэ багийн Иргэдийн нийтийн хуралд оролцсон | 100 % |
| 2. | Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулах | Иххэт сумын ИТХ | 2025 оны 10-р сарын 6-ний өдөр зохион байгуулагдсан Иххэт сумын Бүрдэнэ багийн Иргэдийн нийтийн хуралд оролцсон | 100 % |

### 11.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг танилцуулах

Бид 2025 оны 10-р сарын 06-ний өдөр зохион байгуулагдсан Иххэт сумын Бүрдэнэ багийн Иргэдийн нийтийн хуралд оролцож, байгууллагын үйл ажиллагаа, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, сумын засаг даргатай нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн гэрээний биелэлтийн талаар мэдээллийг танилцуулсан.

### 11.2 Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон БОМТ, ОХШХ-ийн талаарх мэдээллүүдийг танилцуулах

Бид 2025 оны 10-р сарын 06-ний өдөр зохион байгуулагдсан Иххэт сумын Бүрдэнэ багийн Иргэдийн нийтийн хуралд оролцож, байгууллагын үйл ажиллагаа, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, сумын засаг даргатай нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн гэрээний биелэлтийн талаар мэдээллийг танилцуулсан.

## ДҮГНЭЛТ

“Хөх Бишрэлт” ХХК нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн холбогдох заалтууд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2025 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Бид баяжуулах үйл ажиллагаа явагдах газар нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаврыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж ажиллах зорилготой ажилладаг.

Дээрх зорилгын дагуу тухайн жилийн уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулж, 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж түүний биелэлтийг ханган ажиллалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг товч байдлаар нэгтгэн дүгнэвэл:

- БОННҮ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2025 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй 11 сөрөг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.
- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 17 арга хэмжээ төлөвлөснөөс 17 ажлыг хэрэгжүүлсэн буюу тогтмол хэрэгжиж Тус төлөвлөгөөний хэрэгжилт 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 97%-тай байна.
- “Хөх Бишрэлт” ХХК нь “Цагаан Дэл” хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг хариуцлагатай байлгах, байгаль орчны нөхөн сэргээлтийг Монгол улсын холбогдох хууль, эрх зүй, стандарт шаардлагуудад нийцүүлэх, тухайн бүс нутгийн цаг уурын онцлог, ордын геологийн тогтоц, орчин нөхцөлд тохирсон байх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага арга зүйд тулгуурлах, байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зэрэг зарчмуудыг баримтлан ажиллаж байна.
- Тайлант жилд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 3 ажил төлөвлөсөн. Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Иххэт сумын Засаг даргын тамгын газруудтай 2025 онд хэрэгжүүлэх Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний талаар санал солилцсон. Тухайн байгууллагуудаас Иххэт сумын нутагт Монгол тарвага сэргээн нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр болсон. Сэргээн нутагшуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Хустайн Цогцолборт Газар” төв ТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ

байгуулсан. Тус гэрээний хүрээнд тайлант жилд тарвага сэргээн нутагшуулах ажлын судалгааг хэрэгжүүлсэн.

- Дорноговь аймгийн Иххэт сумын Засаг даргын тамгын газартай ярилцсаны үндсэн дээр сумын Бүрдэнэ багийн нутагт орших “Хөх Өндөр” нэртэй орон нутгийн иргэдийн өнгөт чулуу зөвшөөрөлгүй олборлож, нөхөн сэргээлт хийлгүй эвдрэлд оруулан орхисон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг хэрэгжүүлэхээр тохиролцсон. Техникийн нөхөн сэргээлт гүйцэтгэх ажлыг “Хөх Бишрэлт” ХХК нь өөрийн техник, ажиллах хүчээр хийхээр гэрээ байгуулан, гүйцэтгэлийг ханган ажилласан. Нөхөн сэргээлтийн хүрээнд нийт 11.1 га талбайд 2025 оны 10-р сарын 21-ны өдрөөс 10-р сарын 28-ны өдрүүдийн хооронд гүйцэтгэсэн. Гүйцэтгэсэн дүйцүүлэн нөхөн сэргээлтийг Дорноговь аймгийн Иххэт сумын засаг даргын 2025 оны 10-р сарын 21-ний өдрийн А/83 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.
- Тайлант жилд биотехникийн арга хэмжээний хүрээнд мэргэжлийн байгууллагатай хамтран зэрлэг амьтанд өвс, тэжээл тавьж өгөх ажлыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд Дорноговь аймгийн нутагт байршин амьдардаг 5 аргал хонинд 300 боодол өвс тавьж өгөх арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- Иххэт сум үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан түүхэн номыг 65.0 сая төгрөгөөр, байгалийн үзэсгэлэнт болон тусгай хамгаалалттай газар нутгийн танилцуулга номыг 25.0 сая төгрөгөөр санхүүжүүлж хэвлэн, орон нутгийн иргэдэд тараасан.
- Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд нийт 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тухайн арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж дуусан.
- Иххэт сумын ЗДТГ-ын даргатай 2025 оны 01-р сарын 2-ны өдөр №04 тоот “Хог хаягдал ачиж, тээвэрлэх” гэрээ байгуулсан.
- Хог хаягдлын түр цэгт нийт 4 ангилал бүхий хог хаягдлын сав байрлуулсан. Мөн баяжуулах үйлдвэр, ажилчдын амрах байр, гал тогоо, оффисууд зэрэг шаардлагатай байршлуудад 2-оос 3 ангилал бүхий хог хаягдлын савнууд байрлуулсан.
- Ашиглагдсан шатах тослох материалыг хүдэр бутлах механизмын тосолгоонд эргүүлэн ашигладаг. Элемент ХХК-тай 2025 оны 5-р сарын 28-ны өдөр “Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Тайлант жилд нийт химийн бодисын хуванцар сав 385 ширхэг, сав баглаа боодол 2100 кг тус тус устгалд оруулсан байна.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран үйлдвэрийн нийт 52 ажилчдад сургалт зохион байгуулсан.
- Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн талбайд нийт 800 ширхэг улиас мод худалдан авч, тарьсан.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны Газар”-аас 2025 оны 6-р сарын 4-ны өдөр Е-2404-000028 дугаартай “Ус ашиглуулах дүгнэлт” авсан бөгөөд 2025 оны 6-р сарын 12-

ны өдөр “Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаа”-тай 11 дугаар “Ус ашиглах гэрээ”-г байгуулсан.

- Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд MNS 4219:1994 стандартын дагуу экологийн паспорт боловсруулсан.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд Дорноговь аймгийн АУК-д сурдаг 1 оюутаны төлбөрийг төлдөг. 2024 оны зудтай өвөл Бүрдэнэ баг, Баян багийн малчдын айл хоорондын зам, сум орон нутаг орох замыг 7 хоног тутам 2 ковшоор хусах ажил хийсэн. Хавар малын сэг зэм ачиж булшлах ажилд 20 хоног 1 ковш, 3 ажилтан ажилласан байна.
- Орчны хяналт шинжилгээний ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүн, гэрээт компанийн тайланг холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.
- Бид 2024 оны 12-р сарын 6-ний өдөр зохион байгуулагдсан Иххэт сумын Баян багийн Иргэдийн нийтийн хуралд оролцож, байгууллагын үйл ажиллагаа, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд авсан дээж болон хэмжилтийн үр дүнгүүдийн талаар мэдээллийг танилцуулсан.

“Цагаан Дэл” хайлуур жонш баяжуулах үйлдвэрин 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд компанийн удирдлагаас эхлээд гүйцэтгэх түвшний бүх ажилчид, сум орон нутгийн төрийн байгууллага, орон нутгийн иргэн, малчдын бүлэг түүний гишүүдийн оролцоотойгоор амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна.

# Хавсралт материал

## 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ



МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000331517

2014.09.09
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9019078088
/ Хувийн хэргийн дугаар /

5878756
/ Регистрийн дугаар /

Хөхбишрэлт — Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2014.08.07 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

| / Код/ | / Үйл ажиллагааны чиглэл / |
|---|---|
| 2399 | Жонш баяжуулах үйлдвэр |
| 46100 | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа |

| Хугацаагүй | 1 | 188,000.00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Сонгинохайрхан, 4-р хороо, Сайн ноён хан Намнансүрэнгийн гудамж,35-3тоот,
Утас1: 95285248, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ — Г.ЦАГААНХҮҮ
/тамга/ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2024 он 12 сар 09 өдөр

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл**

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Ren овогтой Dewen-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* | *2014.09.09* | *Н.Цэжиддулам* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2024.12.09* | *Г.Цагаанхүү* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000331517

## 2. Ус ашиглах дүгнэлт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 06 -р сарын 12 -ны өдөр

Дугаар Е-2505-000353

Улаанбаатар хот Утас: 265528, 265578

### 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Хөхбишрэлт ГХО-тай ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | 5878756 |
| Захирал: | Dewen |
| Холбоо барих дугаар: | 95285248 |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

### 2.Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Баяжуулах үйлдвэр |
| Байршил: | Дорноговь, Иххэт, 1-р баг, Бүрдэнэ |
| Харьяалагдах сав газар: | Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар |
| Хамаарах салбар: | Уул уурхай |
| Төслийн дэлгэрэнгүй: | Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших "Хөх бишрэлт" ХХК-ний жонш баяжуулах үйлдвэр нь хоногт 300 мян.тн хүдэр боловсруулан баяжуулах хүчин чадалтай. |

### 3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Хөхбишрэлт

### 4. Ажиллах горим, хүчин чадал

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчидын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 1 | 3 ээлжээр | 330 | 110 | 22 |

### 5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
